ХУУЛЬ САНААЧЛАГЧ





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР *3*

УДИРТГАЛ *4*

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ *5*

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох 5

1.2. Үнэлгээний хүрээг тогтоох 6

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох 9

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох 11

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох 12

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 12

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ *13*

2.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журам 13

2.2. Тайлан, судалгааны материал 14

2.3. Шүүхийн практик судалсан байдал 14

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ *15*

3.1 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 15

3.1.1 Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдлын үнэлгээ 15

3.2.1. Улсын Их Хурлын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт 17

3.2.2. Засгийн газрын журам батлах бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт 19

3.2.3. Эрчим хүч хэмнэлтийн талаар Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт 20

3.2.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг даргын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт 23

3.3. ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ 26

3.3.1. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх, үүрэгтэй холбоотой холбоотой зохицуулалт 26

3.3.2. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөртэй холбоотой зохицуулалт 29

3.3.3. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар тайлагналттай холбоотой зохицуулалт 29

3.3.4. Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалт 30

3.4. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГСЛҮҮД ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ 30

3.4.1. Засгийн газраас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмуудын үнэлгээ 30

3.5. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ 35

3.5.1. Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитортай холбоотой зохицуулалт 36

3.5.2. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагатай холбоотой зохицуулалт 39

3.5.3. Эрчим хүчний хэмнэлтийн менежертэй холбоотой зохицуулалт 40

3.6. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ХҮРЭЭН ДЭХ ҮНЭЛГЭЭ 41

3.6.1. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт 41

3.6.2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт 42

3.6.3. Урамшуулал олгохтой холбоотой зохицуулалт 43

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ *45*

4.1. Дүгнэлт 45
4.2. Зөвлөмж 46
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ 48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭХЗХ	Эрчим Хүчний Зохицуулах Хороо
ГОУХАН	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ЭХҮА	Эрчим Хүчний Үр Ашиг
ҮХХ	Үүрэг Хүлээсэн Хэрэглэгч
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ААНБ	Аж Ахуйн Нэгж Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын Даргын 2024 оны 80 дугаар захирамжаар эрчим хүчний салбарын шинэтгэлийн хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийн захиалгаар Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль /цаашид хууль гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн болно.

Энэхүү үнэлгээ хийх ажлын зорилт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Одоо үйлчилж буй Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль нь 2015 онд 6 бүлэг, 17 зүйл, 32 хэсэг, 54 заалттай батлагдсан бөгөөд хамгийн сүүлд 2024 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар 6 бүлэг, 17 зүйл, 32 хэсэг, 53 заалттай хуулийг мөрдөж байна. Мөн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой 5 журам, 2 аргачлал болон 17 стандарт батлан мөрдөж байна. Хуулийн хэрэгжилтийн хугацаанд 2017, 2021, 2022, 2024 онуудад нийт дөрвөн удаагийн нэмэлт өөрчлөлтөөр нийт 8 зүйл, 3 заалтад өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулаагүй ба бусад хууль тогтоомжтой нийцүүлэх эсвэл зүйл заалтуудын утга санааг нарийвчлан тодорхой болгох зорилгоор хийгдсэн.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр сүүлийн 5 жилийн хугацаанд үүрэг хүлээсэн хэрэглэгчид нийт 263.7 сая кВт.ц цахилгааныг буюу 47.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж 197.78 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна. Нөгөөтэйгүүр, хуулийг хэрэгжүүлэх явцад эрчим хүчний үнэ тариф хямд байгаагаас эрчим хүч хэмнэх хөшүүрэг бий болохгүй, эрчим хүч хэмнэх төрийн бодлогыг өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй болон эрчим хүчний хэмнэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжид олгох урамшуулалын тогтолцоо бүрдэхгүй зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд “Хууль тогтоомжийн тухай хууль” болон “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан ажилласан. Үүнтэй холбогдуулан эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн үзэл баримтлал, зорилго, зорилтуудын биелэлт, өнөөгийн нөхцөл байдал, үүсээд буй асуудлууд, мөн тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтын шалтгаан, үр дагаварт дүн шинжилгээ хийж үнэлсэн. Эцэст нь, энэхүү үнэлгээгээр хууль тогтоомжийг сайжруулж, боловсронгуй болгох, шинэчлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай чиглэлийг тодорхойлсон болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан аргачлал [1]-ын дагуу Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

Уг аргачлалын 3.1. дүгээр заалтад төлөвлөх үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг тогтоох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Эдгээр дарааллын дагуу үнэлгээний төлөвлөлтийн үе шатыг хийж гүйцэтгэсэн.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль нь 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан ба Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан 2017 онд, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 2021 онд, 2022 болон 2024 онуудад гээд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт орсон.

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно [1]. Үүний дагуу үнэлгээ хийх дараах шалтгаанууд байна гэж үзэв:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан.
- Мөн Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолоор батлагдсан Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)-ийн 3.1.1-т “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилтыг дэвшүүлж байсан.
- ЭХЯ-наас хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2019, 2020 оны тайлангийн дүгнэлтэд “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна” гэж зөвлөмж өгсөн.
- Эрчим хүчний сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан нэгдүгээр ажлын хэсгийн төлөвлөгөөнд “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах” гэж тусгагдсан.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг өөрчлөх практик хэрэгцээ, шаардлага нь:

- Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрчим хүчний аудитын үйл ажиллагаа, эрчим хүч хэмнэлтийн үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, үүрэг хүлээсэн хэрэглэгч, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх үүрэг тэдгээртэй холбоотой харилцаа;
- Эрчим хүчний хэмнэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбоотой харилцаа;
- Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн болон Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн захиргааны төв байгууллага, аймаг сум, нийслэл дүүргийн Засаг даргын бүрэн эрх, тэдгээртэй холбоотой харилцааг тодорхой, зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Эрчим хүчний хэрэглээний стандарт, босго хэмжээг нарийвчлан тогтоох;
- Эрчим хүчний хэмнэлтийг хэмжих тооцох, баталгаажуулах аргачлал, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

- Бусад хууль тогтоомж, хөгжлийн бодлоготой нийцүүлэх.

Үнэлгээний зорилго нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн тодорхой зүйл, заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, гарч буй хүндрэл бэрхшээлийг тогтоож, цаашид оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдсэн болно.

1.2. Үнэлгээний хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ [1] гэж заасны дагуу Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд ач холбогдолтой, тулгамдаж буй асуудалд холбогдох (тус хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай оролцогч талууд болон хэрэгжүүлэх механизмуудыг сонгож тэдгээрээс гарч болох эерэг үр дагавар эсвэл дутуу хэрэгжиж байгаа заалтуудтай холбоотой) дараах зохицуулалтыг сонгон авч үнэлгээний хүрээг тогтоосон *(Хүснэгт 1)*. Үүнд:

Хүснэгт 1. Үр дүнгийн үнэлгээний хүрээ

Үнэлгээний хүрээ	**Заалтууд**
Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдал	1.1.Энэ хуулийн зорилт нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. 2.1 Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 3.1.2."эрчим хүч хэмнэлт" гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ-ний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг; 3.1.3."эрчим хүчний үр ашиг" гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүч-ийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг; 3.1.1. "эрчим хүч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.1-д заасныг; Эрчим хүчний тухай хуулийн заалт: 3.1.8. "үүрэг хүлээсэн хэрэглэгч" гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг
Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх • Улсын Их Хурал • Засгийн газар • Төрийн Захиргааны төв байгууллага • Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг дарга	**Улсын Их Хурал** 4.1 Улсын Их Хурал эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг тодорхойлно. **Засгийн Газар** 5.1 Засгийн газар эрчим хүч хэмнэлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.1 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах; 5.1.3 энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах. **Төрийн захиргааны төв байгууллага** 6.1 Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 6.1.2 эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах; 6.1.3 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.

	Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг дарга 7.1 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана. 7.2 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. 7.3 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.
Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх • Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл • Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр • Эрчим хүч хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн тайлан • Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой маргаан шийдвэрлэх	8.1.Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ. 8.2.Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна. 9.1.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; 9.1.2.эрчим хүч хэмнэлтийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах; 9.1.3.үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар хийсэн ажлын жилийн тайлан, гүйцэтгэлийг гаргуулж авах; 9.1.4.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх; 9.1.5.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох; 9.1.6.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох; 9.1.7.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийн систем бүрдүүлэх, энэ талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.8.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.10.эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах; 9.1.11.эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх. 9.2.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь энэ хуулийн 9.1.7, 9.1.8-д заасан бүрэн эрхийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.
Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хэрэгслүүд • Засгийн газраас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмууд • Батлагдаагүй журмууд: урамшуулал олгох журам, шошгожуулах журам	**Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам** 9.1.9.дараах журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах: 9.1.9.а.энэ хуулийн 13.3, 13.4-т заасан үйл ажиллагаатай холбогдсон эрчим хүчний аудит хийх; 9.1.9.б.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой журам; 9.1.9.в.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбоотой журам; 9.1.9.д.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам; **Батлагдаагүй журам** 9.1.9.г.эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам; 9.1.9.е.эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам;

Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ • Эрчим хүчний хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллага, аудитор • Эрчим хүчний хэмнэлтийн менежер • Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага	**Эрчим хүчний хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллага, аудитор** 13.3. Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор дараах эрхтэй: 13.3.1. Эрчим хүчний аудитын үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай тайлбар, материалыг үүрэг хүлээсэн хэрэглэгчээс гаргуулж авах; 13.3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргах. 13.4. Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор дараах үүрэгтэй: 13.4.1. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээ, үр ашгийг тооцох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах; **Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага** 14.1. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь магадлан итгэмжлэлийн үндсэн дээр эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих чиглэлээр үйл ажиллагааг явуулна. 14.2. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 14.3. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна. **Эрчим хүч хэмнэлтийн менежер** 15.2.2. Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах; 15.2.3. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;
Эрчим хүч хэрэглэгчийн эрх, үүрэг • Үүрэг хүлээсэн хэрэглэгч • Иргэн, аж ахуйн нэгж байгууллага • Урамшуулал	**Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэг** 10.1.Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь дараах эрхтэй: 10.1.1.эрчим хүчний аудитын байгууллагыг сонгох, 10.1.2.эрчим хүчний аудитын зөвлөмж, дүгнэлтийн талаар үндэслэлтэй тайлбар өгөхийг шаардах, 10.1.3.энэ хуулийн 13.4.2-т заасан зөвлөмжийг сонгон хэрэгжүүлэх, 10.1.4.эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд урамшуулал эдлэх, 10.2.Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах үүрэгтэй 10.2.1.эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх, 10.2.2.эрчим хүчний хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх, 10.2.3.өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, 10.2.4.эрчим хүчний аудитын тайлан, эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх, 10.2.5.эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилох, чөлөөлөх, энэ тухай Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх, 10.2.6.эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон гомдлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх. **Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх** 11.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй: 11.1.1.эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас зөвлөгөө авах, 11.1.2.сайн дурын үндсэн дээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийлгэх, **Урамшуулал** 12.1. Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулна.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4-т заасны дагуу шалгуур үзүүлэлт нь үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байх бөгөөд оновчтой, бодит, хэмжигдэхүйц байна гэж заасныг үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Судалгааны хүрээнд дараах зүйл заалтыг **"*Практикт нийцэж байгаа байдал*"** шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Хүснэгт 2. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр үнэлэх заалтууд

№	Үнэлгээний хүрээ	Сонгосон зүйл, заалт
1	Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	4.1 Улсын Их Хурал эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг тодорхойлно. 5.1 Засгийн газар эрчим хүч хэмнэлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.1 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах; 5.1.3 энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах. 6.1 Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 6.1.2 эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах; 7.1 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана. 7.2 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. 7.3 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.
2	Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага	14.2. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 14.3. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна.
3	Эрчим хүч хэмнэлтийн менежер	15.2.1. Эрчим хүч хэмнэлтийн менежер зөвлөлөөс тодорхойлсон үйл ажиллагааны чиглэлийг мөрдөж ажиллах; 15.2.2. Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах; 15.2.3. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих; 15.2.4. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд жил бүр ажлаа тайлагнах; 15.2.5. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа мэргэжлийн сургалтад хамрагдах.
4	Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх	8.1.Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

		8.2.Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна. 9.1.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; 9.1.3.үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар хийсэн ажлын жилийн тайлан, гүйцэтгэлийг гаргуулж авах; 9.1.4.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх; 9.1.5.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох; 9.1.6.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох; 9.1.7.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийн систем бүрдүүлэх, энэ талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.8.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.10.эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах; 9.1.11.эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх. 9.2.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь энэ хуулийн 9.1.7, 9.1.8-д заасан бүрэн эрхийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.
5	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хэрэгслүүд	9.1.9.а.энэ хуулийн 13.3, 13.4-т заасан үйл ажиллагаатай холбогдсон эрчим хүчний аудит хийх журам; 9.1.9.б.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой журам; 9.1.9.в.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбоотой журам; 9.1.9.д.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам; 9.1.9.ж.холбогдох бусад дүрэм, журам

“Зардал, үр өгөөжийн харьцаа” буюу тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, гарсан үр өгөөжийн харьцааг тооцон гаргах шалгууруар дараах зүйл, заалтыг үнэлнэ:

Хүснэгт 3. Зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтээр үнэлэх заалтууд

№	Үнэлгээний хүрээ	Сонгосон зүйл, заалт
1	Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор	13.3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргах; 13.4.2. Үүрэг хүлээсэн хэрэглэгчид эдийн засгийн үр ашигтай, техникийн үндэслэлтэй зөвлөмжийг гаргаж өгөх;

Зорилгод хүрсэн түвшин тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тооцон гаргах шалгууруар дараах зүйл, заалтыг үнэлнэ.

Хүснэгт 4. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр үнэлэх заалтууд

№	Үнэлгээний хүрээ	Сонгосон зүйл, заалт
1	Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдал	1.1.Энэ хуулийн зорилт нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. 2.1 Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

		3.1.2."эрчим хүч хэмнэлт" гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ-ний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг; 3.1.3."эрчим хүчний үр ашиг" гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүч-ийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг; 3.1.1. "эрчим хүч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.1-д заасныг; Эрчим хүчний тухай хуулийн заалт: 3.1.8. "үүрэг хүлээсэн хэрэглэгч" гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг
2	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хэрэгслүүд	9.1.9.г.эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам; 9.1.9.е.эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам;
3	Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх	9.1.2.эрчим хүч хэмнэлтийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах;
4	Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	6.1.3 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.
5	Урамшуулал олгохтой холбоотой зохицуулалт	12.1. Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулна.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглана. Байвал зохих үзүүлэлтийг хууль тогтоомжид тодорхой заагаагүй бол хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал, тоо баримттай харьцуулж болно [1] гэж заасан байна.

Хүснэгт 5. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр үнэлэх заалтууд

Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдал	Зорилгод хүрсэн түвшин	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хэрэгслүүд	Практикт нийцэж байгаа байдал	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор	Зардал - Үр өгөөжийн харьцаа	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш
Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хэрэгслүүд	Зорилгод хүрсэн түвшин	Байх ёстой болон одоо байгаа

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсвэл асуулт тавихыг хэлнэ [1]. Тус хуулийн хувьд сонгосон шалгуур үзүүлэлтүүд (Практикт нийцэж байгаа байдал, Зардал - Үр өгөөжийн харьцаа болон Зорилгод хүрсэн түвшин)-ийн хүрээнд харьцуулах хэлбэртэй уялдуулан томъёолох хэлбэрээ сонголоо. Томъёолох хэлбэрийг дараах асуултуудыг асуух байдлаар тогтоолоо.

- Практикт нийцэж байна уу?
- Зорилгодоо хүрсэн эсэх?
- Хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардал, гарсан үр өгөөжийн харьцаа оновчтой байна уу?

Мөн түүнчлэн хуулийн зүйл заалтуудын онцлог, түүний агуулга, зохицуулалтын шинж чанар зэргээс хамааран хуулийг хэрэгжүүлэгч тал, оролцогч талуудаас цуглуулсан баримт материал дээр үндэслэн асуулт асуух замаар үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд [1] заасан мэдээлэл цуглуулах аргуудаас “бэлэн байгаа мэдээлэл цуглуулах” болон “холбогдох субъектээс судалгаа авах”, биечлэн судалгаа хийхдээ хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлийн холбогдох газрын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх гэсэн аргуудыг ашигласан. Хэрэгжүүлэх үе шат бүлэгт цуглуулсан мэдээллийн дэлгэрэнгүй жагсаалтыг оруулсан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг энэ үе шатанд гүйцэтгэнэ [1]. Дээр дурдсан аргуудын хүрээнд цуглуулсан баримт бичиг, тайлан төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, нээлттэй асуулга болон ярилцлагын арга зэрэг хууль зүйн судалгааны үндсэн аргыг ашиглалаа. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөл болон Эрчим хүчний асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж буй ажил үүрэгтэй холбоотой дүрэм, журам, норм стандартууд, тайлан, төлөвлөгөө болон бусад баримт бичгийг албан бичгээр хандан татан авсан. Ирүүлсэн баримт бичиг болон бусад цахим эх сурвалжуудад үндэслэн үнэлгээг гүйцэтгэлээ.

1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журам
2. Хуулийн хэрэгжилтэд оролцогч талуудаас авсан судалгаа, үнэлгээний тайлан
3. Шүүхийн практик

2.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журам

1. Эрчим хүчний тухай хууль - 2001 он;
2. Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль - 2015 он;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль - 1995 он;
4. Агаарын тухай хууль - 2013 он;
5. Барилгын тухай хууль - 2016 он;
6. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоол;
7. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;
8. “Шинэ сэргэлтийн бодлого” батлах тухай УИХ-ын 2021 оны 106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт;
9. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл” батлах тухай 2020 оны 23 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт;
10. “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлах тухай 2024 оны 21 дүгээр тушаал;
11. “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр” батлах тухай Засгийн Газрын 2017 оны 274 дүгээр тогтоол;
12. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Эрчим хүчний аудит хийх журам”;
13. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”;
14. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”;
15. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 295 дугаар тогтоол “Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам”;
16. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 503 дугаар тогтоол “Эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлал”;
17. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал ".

2.2. Тайлан, судалгааны материал

1. Эрчим хүчний зохицуулах хорооны “Эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлсэн тайлан”- Эрчим хүч хэмнэлтийн газар, 2024 он;
2. Эрчим хүчний зохицуулах хорооноос явуулсан “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс авах санал асуулга”, 2024 он;
3. Эрчим хүчний зохицуулах хорооноос явуулсан “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой аймаг, нийслэлийн засаг дарга нараас авсан санал асуулга”, 2024 он;
4. Эрчим хүчний зохицуулах хорооноос явуулсан “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой эрчим хүчний аудиторуудаас авсан санал асуулга”, 2024 он;
5. Эрчим хүчний зохицуулах хорооноос явуулсан “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой яамдуудаас авсан санал асуулга”, 2024 он;

2.3. Шүүхийн практик судалсан байдал

Монгол Улсын шүүхийн цахим сангаас Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд тус хуультай холбоотой гарсан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол бүртгэгдээгүй байна.

Харин 2021 онд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль зөрчиж, Зөрчлийн тухай хуулийн 12.9.1 дүгээр заалт буюу үүрэг хүлээсэн хэрэглэгч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр 1 үүрэг хүлээсэн хэрэглэгч 3,000,000 төгрөгийн торгуулиар шийтгэгдэж байсан байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд сонгосон үнэлгээний ажлыг эцэслэн үр дүнг нэгтгэн дүгнэж, зөвлөмж боловсруулна [1]. Ингэхдээ дараах дарааллыг баримталж ажиллана:

- Цуглуулсан мэдээллийг үнэлэх
- Тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлэх

Тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан дараах байдлаар үнэлнэ:

- Хууль тогтоомж хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэхийг судлах;
- Мэдээллийг задлан шинжилсний үндсэн дээр тоон болон чанарын үнэлэлт өгөх;
- Бусад хууль, дэд акттай харьцуулах;
- Үнэлгээний үр дүнгийн түвшинд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн шинжилгээ хийх.

Томъёолсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дор дурдсаны дагуу дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулна:

- Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах;
- Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргаж болох бөгөөд дараах саналыг гаргаж болно:

Тухайн хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүнтэй байгаа бол хэвээр нь үлдээх;

- Тухайн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Тухайн хууль тогтоомжийг шинэчлэн найруулах;
- Тухайн хууль тогтоомж, түүний зарим зүйл, заалтыг хүчингүй болгох.

3.1 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

3.1.1 Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдлын үнэлгээ

Хүснэгт 6. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр үнэлэх заалтууд

Үнэлэгдэх хэсэг	1.1.Энэ хуулийн зорилт нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. 2.1 Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 3.1.2."**эрчим хүч хэмнэлт"** гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ-ний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг; 3.1.3."**эрчим хүчний үр ашиг"** гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүч-ийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг; 3.1.1. "**эрчим хүч"** гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.1-д заасныг; Эрчим хүчний тухай хуулийн заалт: 3.1.8. "**үүрэг хүлээсэн хэрэглэгч"** гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш
Томьёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн зорилт, нэр томъёо нь үзэл баримтлалдаа нийцсэн үү?

Хуулийн зорилт, хамрах хүрээ болон нэр томъёоны нийцтэй байдлыг үнэлэхийн тулд тухайн хуулийг боловсруулах үеийн анхны үзэл баримтлал болон хууль батлах болсон шалтгааныг тодорхойлох шаардлагатай.

“Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал” [24] баримт бичигт дурдсанаар:

Эдийн засаг, нийгмийн суурь салбаруудад хамааралтай асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тус хуулийг батлах хэрэгцээ шаардлага үүссэн байна. Үүнд:

1. Улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
2. Зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
3. Ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах;
4. Эдийн засаг, нийгэм, байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудыг шийдэх.

Эдгээр асуудлуудыг шийдэхийн тулд:

- Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил;
- Төрийн нэгдсэн бодлого;
- Техник, технологийг шинэчлэх замаар.

Дараах хүчин зүйлүүдэд өөрчлөлтийг оруулах хүлээлттэйгээр тус хуулийн төслийг анх баталсан байна. Үүнд:

- Эрчим хүчний хэрэглээний бүхий л түвшинд үр ашгийг нэмэгдүүлэх;
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах;
- Мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх;
- Нийтийн боловсролд чиглэсэн эрчим хүч хэмнэлт, техник технологийн талаарх мэдээлэл, сурталчилгааны нэгдсэн системийг бий болгох;
- Барилга байгууламжийн зураг төсөлд эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатай шийдлүүдийг тусгах;
- Барилгын салбарын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, мөрдүүлэх байдлаар дээр дурдсан асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх” хэмээн тодорхойлсон байна [24].

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь “*Эрчим хүч хэмнэх, үр ашигтай **хэрэглэх**-тэй холбоотой харилцааг зохицуулах*” гэж заасан. Мөн хуулийн 2.1 заалтанд уг хууль нь *“Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ”* гэж заасан. Мөн Эрчим хүчний тухай хуульд:

3.1.1. "***эрчим хүч***" гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг;

3.1.19. ***"хэрэглэгч"*** гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчийг худалдан авах эрхтэйгээр

оролцож байгаа **иргэн, хуулийн этгээд**-ийг; гэж тодорхойлсон.

Харин Засгийн Газрын 2019 оны 181 дүгээр тогтоол 3 дугаар хавсралтаар баталсан журмын 2.2 дахь заалтаар Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг Хүснэгт 7-д заасан байдлаар ангилсан байна. Энэ ангилалд эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлж буй эрчим хүчний системийн оролцогч талуудыг журмын 2.5 дахь заалтад эрчим хүч үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч аж ахуйн нэгж байгууллага болгон Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилалд хамруулан авч үзсэн нь Эрчим хүчний тухай хуульд томъёолсон оролцогч талууд, тэр дундаа хэрэглэгч гэсэн ойлголттой зөрчилдөж байна.

Хууль, тогтоомжийн тухай хуульд *“30.1.Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна: 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх; 30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх; 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;”* гэж заасан. Тиймээс Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн нэр томьёог дээрх шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Мөн Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн зорилтыг “Эрчим хүч хэмнэх, үр ашигтай **хэрэглэх**-тэй холбоотой харилцааг зохицуулах” гэж заасныг хуулийн төслийн үзэл баримтлал болон практикт хэрэгжиж буй байдалд нийцүүлэн *“Эрчим хүч хэмнэх, үр ашигтай **үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хэрэглэх**-тэй холбоотой харилцааг зохицуулах”* болгон нарийвлан тусгах нь оновчтой гэж үзэж байна. Үүнтэй адилаар, хуулийн нэр болох “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийг *“Эрчим хүч **хэмнэлт, үр ашгийн** тухай хууль”* болгон өөрчлөх нь зүйтэй. Үүнтэй холбогдуулан нэр томъёо тодийгүй хуулийн хамрах хүрээ, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг нарийн тодорхой тусган шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн нэр томъёо, зорилт, хамрах хүрээ, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг хуульд нарийн тодорхой тусгах нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн гол зорилго болсон эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг бүхий л шатанд нэмэгдүүлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах болон хууль нь зорилгодоо хүрэхэд чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 7. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал

2.2	**Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг дараах байдлаар ангилна:**
2.2.1	барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага;
2.2.2	эрчим хүч хэрэглэгч;
2.2.3	эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага.
2.3	Энэ журмын 2.2.1-д заасан этгээд нь дараах төрөлтэй байна:
2.3.1	төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага;
2.3.2	бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.
2.4	Энэ журмын 2.2.2-т заасан этгээд нь дараахь төрөлтэй байна:
2.4.1	уул уурхайн (олборлолт, боловсруулалт) чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага;
2.4.2	бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага.
2.5	Энэ журмын 2.2.3-т заасан этгээд нь дараахь төрөлтэй байна:
2.5.1	эрчим хүч үйлдвэрлэгч;
2.5.2	эрчим хүч дамжуулагч;
2.5.3	эрчим хүч түгээгч.

3.2. ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

3.2.1. Улсын Их Хурлын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 8. УИХ-ын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтын шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	4.1. Улсын Их Хурал эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг тодорхойлно.
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 4.1 дахь заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд Улсын Их Хурлаас баталсан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрчим хүч хэмнэлтийн талаар тусгагдсан заалтуудыг доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 9. Бодлогын баримт бичгүүдэд хэмнэлтийн талаар тусгагдсан заалтууд.

Бодлогын баримт бичиг	Батлагдсан	Хүчингүй болсон	Эрчим хүчний хэмнэлтийн талаарх төрийн бодлого тусгагдсан заалтууд
2015-2030 он хүртэлх Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого УИХ-ын 63-р тогтоолоор	2015.6.19	2021.11.12	3.2.5.Стратегийн тавдугаар зорилго буюу эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд: 3.2.5.1.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд бүрэн шилжүүлж нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох; 3.2.5.2.эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх; 3.2.5.3.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээн дэх алдагдлыг бууруулах; **3.2.5.4.үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх;**
“Алсын хараа-2050” 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа УИХ-ын 52-р тогтоолоор	2020.5.13	Хүчин төгөлдөр	4.2.41.Эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн бие даасан, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. 6.4.10.Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ. **9.3.36.Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.**
Шинэ сэргэлтийн бодлого УИХ-ын 106-р тогтоолоор	2021.12.30	Хүчин төгөлдөр	5.2.2 Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах 5.4.3 Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, эрчим хүч, цэвэр усны хэмнэлттэй ногоон төсөл хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүн худалдан авахад хөнгөлөлттэй зээл, урамшуулал олгох

Монгол улсын Засгийн газрын 274-р тогтоолоор “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)" - ийг 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан 18 зорилт, 87 арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн зорилтын хүрээнд 7 яам болон холбогдох төрийн байгууллага, аудитын байгууллага, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, Үүрэг хүлээсэн хэрэглэгчид, аймаг нийслэлийн Засаг дарга нар болон ЗДТГ, Олон Улсын байгууллага, ШУТИС-ийн харьяа Эрчим хүчний сургууль, төрийн бус байгууллагууд, МҮХАҮТ зэрэг байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган нэгтгэн зохион байгуулж ажилласан [9]. Мөн 2021 оны байдлаар УБ хотын хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөтэй болсон, харин 21 аймгаас 13 аймаг нь орон нутгийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлсэн [13]. Эндээс харахад уг хөтөлбөр нь Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Гэтэл Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан зарим бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 314-р тогтоолоор 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүчингүй болгосон. Үүнд Эрчим хүчний салбарт мөрдөгдөж байсан Төрөөс Эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030) болон Эрчим хүчний хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022) багтсан. Мөн уг хуульд нийцүүлэх зорилгоор Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 5-р зүйлд буюу Засгийн газрын бүрэн эрхэд тусгагдсан 5.1.2.эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах заалтыг хүчингүй болгосон. Үүнтэй холбоотойгоор, эрчим хүч хэмнэлтийн талаар бодлогыг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн [13].

Дээрх хүснэгтэнд үзүүлсэнчлэн “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгагдсан боловч 2021 оноос хойш үндэсний хөтөлбөр боловсруулагдан батлагдаагүй. Мөн дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болох “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн бодлого төдийлөн нарийн тусгагдаагүй байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт *“3.3.3.18.Эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.”* зэрэг цөөн тооны заалтууд тусгагдсан байна.

Төрийн бодлого нь зөвхөн хуулийн болон бодлогын баримт бичгүүдэд тусгагдахаас гадна практикд хэрэгжиж, үр дүнгээ өгч чадах тогтолцоо, хөтөлбөрийг бий болгох нь нэн чухал. Тиймээс цаашид Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн бодлогын тогтвортой орчинг бүрдүүлэх, эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хөгжлийн бодлого болон бусад хууль тогтоомжинд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.2.2. Засгийн газрын журам батлах бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 10. Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтын шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	5.1. Засгийн газар эрчим хүч хэмнэлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах; ~~5.1.2. эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах;~~ 5.1.3 энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах.
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 5.1.1 болон 5.1.3 дахь заалтууд практикт хэр хэрэгжиж байна вэ?

5.1.1. дахь заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Засгийн газар нь Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангаж ажиллаж байна. Тухайлбал, Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны дээд байгууллага нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн жил бүр засгийн газарт тайлагнадаг.

5.1.3. дахь заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

9.1.9.-т заасан журмаас дараах хоёр журам батлагдаагүй.

- 9.1.9.г.эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам;
- 9.1.9.е.эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам;

Эдгээр журмын төслүүдийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс боловсруулан Засгийн газарт удаа дараа өргөн барьсан боловч тодорхой шалтгааны улмаас батлагдаагүй байна. Үүнтэй холбоотой үр дагаврын үнэлгээг тайлангийн 3.4.2. хэсгээс харна уу. Урамшууллын журам батлагдаагүйгээс шалтгаалан Эрчим

хүч хэмнэлтийн тухай хууль хангалтгүй хэрэгжиж, Үүрэг хүлээсэн хэрэглэгч, иргэн, бусад аж ахуй нэгж байгууллагын эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх санал, санаачлага хангалтгүй байна.

Тиймээс цаашид эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

3.2.3. Эрчим хүч хэмнэлтийн талаар Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 11. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтын шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	6.1 Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 6.1.2 эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах; 6.1.3 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг ерөнхий байдлаар хуульчилсан нь хэр оновчтой вэ? 6.1.3 заалт зорилгод хүрсэн эсэх? Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбоотой 6.1.1-6.1.2 заалтууд практикт нийцэж байна уу?

Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг нийтлэг байдлаар хуульчилсан нь хэр оновчтой вэ? 6.1.3 заалт зорилгод хүрсэн эсэх?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчгийг “төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх” гэж тодорхойлж 6.1-т төрийн захиргааны төв байгууллагаа тодотголгүйгээр шууд бүрэн эрхийг заасан байна. Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.” гэж тодорхойлсон. Засгийн газрын бүтцийн тухай хуулиар ерөнхий чиг үүргийн 4, чиглэлийн 12 яам байхаар заасан.

Харин Эрчим хүч хэмнэлтийн хуульд төрийн захиргааны төв байгууллага гэж тодорхойлснооро аль асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох нь ойлгомжгүй, эргэлзээтэй байдлыг төрүүлэхээр байна. Өөрөөр хэлбэл, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.3 дахь заалтад заасан бүрэн эрх нь зөвхөн эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хамаарах уу эсхүл ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн бүх яаманд хамаарах уу гэдэг нь тодорхойгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн төслийн хэл зүй, найруулга нь хоёрдмол утгагүй, энгийн ойлгомжтой, тодорхой, ойлгоход хялбар байх шаардлагыг тавьсан байдаг.

Хууль зүйн яамны зүгээс 2015-06-12-ны өдрийн 1/2300 тоот албан бичгээр Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн төсөлд санал өгөхдөө уг заалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж тодотгосон [12] ба Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.3 дахь заалтуудыг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байна.

Гэсэн хэдий ч, Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар 2024 оны байдлаар Эрчим хүчний яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам,

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам тэргүүтэй 8 яам хооронд харилцаа үүсдэг ч салбар хоорондын уялдаа хангалтгүй байна. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн 2024 оны танилцуулгад салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй бөгөөд Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн болон Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн захиргааны төв байгууллага, тэдгээртэй холбоотой харилцааг тодорхой, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай талаар тусгасан [2].

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль нь эрчим хүчтэй холбоотой **эдийн засаг, нийгмийн бүхий л салбарыг хамаарах**ын зэрэгцээ, Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, эрчим хүч хэмнэлтийн талаар нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий нэгж, эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, үүрэг хүлээсэн хэрэглэгч, эрчим хүч хэмнэлтийн менежер болон тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах юм.” гэж тусгасан. Тиймээс Эрчим хүч хэмнэлтийн хууль болон төрийн бодлого нь эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт хамаарах учир салбар хоорондын уялдаа холбоог нарийн зохицуулах шаардлагатай.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.2 заалтууд нь зөвхөн эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хамаарах боломжтой ч 6.1.3 дахь заалт *“6.1.3 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.”* нь эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж буй бүх төрийн захиргааны төв байгууллагад хамаарах нь оновчтой юм.

Түүнчлэн, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс 2024 онд Үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс авсан Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох санал асуулгын хүрээнд [7]:

1. Төрийн байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдсан гэж үзэж байна уу? гэсэн асуулгад 75% (21 хүн) нь үгүй буюу сайжруулах хэрэгцээ шаардлагатай.
2. Эрчим хүч хэмнэлтийн талаарх салбар хоорондын бодлогын уялдаа хангагдсан гэж үзэж байна уу? гэсэн асуулгад 93% (26 хүн) нь үгүй буюу сайжруулах хэрэгцээ шаардлагатай гэж хариулсан байна.

Тиймээс эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хамрах хүрээ хязгаарыг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай байна.

<u>6.1.1 дахь заалт практикт нийцэж байна уу?</u>

Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны дээд байгууллага нь эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулдаг. Мөн Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны дээд байгууллага нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн засгийн газарт тайлагнадаг.

Хуулийн 6.1.1 дахь заалтад *“**үндэсний хөтөлбөр**ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;”* гэсэн хэсэг бий. Дээр дурдсанчлан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор хуулийн “*5.1.2 эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах;”* заалтыг хүчингүй болгосон ба 2021 оноос хойш үндэсний хөтөлбөр хэрэгжээгүй байна. Тиймээс Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6.1.1 дахь заалтыг бусад хууль тогтоомж, хөгжлийн бодлоготой нийцүүлэн шинэчлэх практик хэрэгцээ шаардлага үүссэн байна.

6.1.2 дахь заалт практикт нийцэж байна уу?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш 6.1.2 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд олон улсын норм, стандартыг судалж эрчим хүч, байгаль орчин, барилга, автотээврийн салбарт стандарт батлуулах болон нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар ажиллаж байна [13].

Тухайлбал, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс санаачлан 2019-2020 онуудад эрчим хүчний менежментийн бүлэг стандарт, цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой стандарт болон эрчим хүчний аудитын бүлэг стандарт бүхий нийт 17 стандартыг үндэсний болгон батлуулсан [2]. Мөн 2024 онд батлуулахаар эрчим хүчний менежментийн тогтолцооны бүлэг стандарт, хэмжилт баталгаажуулалттай холбоотой нийт 7 стандартыг боловсруулан ажиллаж байна [2]. Стандартуудыг жагсаалтаар доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. 2019-20 онуудад батлуулсан стандартууд.

#	Зориулалт	Стандартууд	
1	*Олон улсын стандартын байгууллага /ISO/*	Эрчим хүчний менежментийн тогтолцооны бүлэг стандарт	1. MNS ISO 50001:2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх арга зүйн заавар 2. MNS ISO 50002:2019 Эрчим хүчний аудит –шаардлага, хэрэглэх арга зүйн заавар 3. ISO 50003:2019, Эрчим хүчний менежментийн тогтолцоо – эрчим хүчний менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага 4. MNS ISO 50004 : 2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо –эрчим хүчний менежментийн тогтолцооны хэрэгжүүлэлт, хадгалалт, сайжруулалтын арга зүйн заавар 5. MNS ISO 50006 : 2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо —эрчим хүчний суурь түвшин (эхст) болон эрчим хүчний гүйцэтгэлийн үзүүлэлт (эхгү)-ийг ашиглан эрчим хүчний гүйцэтгэлийг хэмжих нь –зарчим арга зүйн заавар 6. MNS ISO 50007 : 2019 Эрчим хүчний үйлчилгээ —Эрчим хүчний хэрэглэгчийн үйлчилгээг үнэлэх ба сайжруулах арга зүйн заавар
2	*Олон улсын цахилгаан техникийн хороо /IEC/*	Цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой стандарт /**Шошгожуулалтын журам**/	1. MNS IEC 60034-2-1:2019 Эргэлдэгч цахилгаан машин 2-1-р хэсэг: Туршилтаас алдагдал болон А.Ү.К-ийг тодорхойлох стандарт аргууд (зүтгүүрийн машины хөдөлгүүрийг оруулаагүй болно) 2. MNS IEC 60034-30-1:2019 Эргэлдэгч цахилгаан машин: Сүлжээнээс ажилладаг хувьсах гүйдлийн хөдөлгүүрийн А.Ү.К-ийн ангилал (IE код) 3. MNS IEC 60076-20: 2019 Хүчний трансформатор –Бүлэг 20: Эрчим хүчний үр ашиг 4. MNS IEC 60076-8:2019 Хүчний трансформаторын гарын авлага
3		Цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой стандарт /**Шошгожуулалтын журам** /	1. IEC 62552-3:2020 Ахуйн хэрэглээний зориулалттай хөргөгч хөлдөөгч, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд; 2. IEC 60456:2020 Ахуйн хэрэглээний зориулалттай угаалгын машин, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд; 3. IEC 60350-1: 2020 Цахилгаан зуух буюу плитк тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд;
4	*Европын холбоо /EN/*	Эрчим хүчний аудит	MNS EN 16247 Эрчим хүчний аудит. 4 бүлэг стандарт: *1. MNS EN16247-1:2019 Эрчим хүчний аудит. Ерөнхий шаардлага,* *2. MNS EN16247-2:2019 Эрчим хүчний аудит. Барилга,* *3. MNS EN16247-3:2019 Эрчим хүчний аудит. Үйлдвэрлэл,* *4. MNS EN16247-4:2019 Эрчим хүчний аудит. Тээвэр*

Хүснэгт 13. 2024 онд батлуулахаар төлөвлөсөн стандартууд [2].

#	Зориулалт	Стандартууд	
1	*Олон улсын стандартын байгууллага*	Эрчим хүчний менежментийн тогтолцооны бүлэг стандарт	1. ISO 50046:2019, Эрчим хүчний хэмнэлтийг урьдчилан таамаглах ерөнхий аргууд 2. ISO 50047:2016, Эрчим хүчний хэмнэлт —Байгууллагын түвшинд эрчим хүчний хэмнэлтийг тодорхойлох 3. ISO 50049:2020, Улс орон, бүс нутаг, хотын түвшинд эрчим хүчний үр ашиг, эрчим хүчний хэрэглээний өөрчлөлтийг тооцоолох арга
2	*Европын холбоо*	Хэмжилт баталгаажуулалттай холбоотой стандарт	1. EN 1434-1:2016, Дулааны эрчим хүчний тоолуур, Хэсэг 1: Ерөнхий шаардлага 2. EN 1434-2:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 2: Суурилуулахад тавигдах шаардлага 3. EN 1434-3:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 3: Өгөгдөл, мэдээллийн солилцоо ба интерфейс 4. EN 1434-4:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 4: Туршилт, тохируулга хийх

Тайлбар: *Төрийн өмчийн байгууллагуудыг тоолууржуулах тухай 144-р тогтоолын хэрэгжилтийг хангахад дулааны тоолуурыг стандартыг шинэчлэн сайжруулах хүрээнд Европын холбооноос 2016 онд шинэчлэн баталсан дулааны тоолуурын EN 1434 багц стандартыг үндэсний стандарт болгон батлуулах ажлыг зохион байгуулсан. ЭХЭЗХ -ийн эрдмийн зөвлөлөөр орохоор бэлтгэгдэж байна. -Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн. Стандарт хэмжилзүйн газрын дэргэдэх Эрчим хүчний техникийн хорооны хурлаар оруулахаар хүргүүлсэн.*

3.2.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг даргын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 14. Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг даргын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтын шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	7.1 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана. 7.2 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. 7.3 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 7.1-7.3 дахь заалтууд практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах, эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэхээр заасан.

Мөн Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)-ийн 4.9.1-д *“тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогт тохирсон эрчим хүч хэмнэлтийн талаарх бодлогыг тодорхойлж аймаг, нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх”* талаар тусгасан. 2021 оны байдлаар, Улаанбаатар хот эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөтэй болсон бөгөөд, 21 аймгаас 13 аймаг нь орон нутгийн эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн [13].

Харин 2023 оны байдлаар, ердөө 4 аймаг л эрчим хүч хэмнэлтийн чиглэлд төлөвлөгөө боловсруулсан байна. Тухайлбал, Эрчим хүч хэмнэлтийн газраас 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 1/1264, 2022 онд орон нутагт эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан ирүүлэх, 2023 оны 06 сарын 27-ны 1/695 Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж хамтран ажиллах тухай зэрэг Эрчим Хүчний Зохицуулах Хороон даргын нэр дээр 2 удаа орон нутагт албан бичиг явуулсан. Тус албан бичгийн хүрээнд Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймгууд 2023 оны төлөвлөгөө ирүүлсэн

ба нийт 1,864 тэрбум төгрөг төсөвлөөд *Барилга байгууламжийн дулаан алдагдал бууруулах, Шугам сүлжээний дулаан алдагдал бууруулалт, шинэчлэл, Гудамж, талбай болон аж ахуй нэгжийн улайсдаг чийдэнг хэмнэлттэй Лед гэрлээр шинэчлэх, Хэмнэлтийн сургалт сурталчилгаа зохион байгуулалт, Дулааны тоолууржуулалт, Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх* зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна. Бусад аймгуудын хувьд утас болон албан мэйлээр мэдээлэл өгсөн боловч орон нутагт ажиллах хүчний хомсдолтой байгаа тул тухайн ажлыг хийх албан тушаалтан томилох боломжгүй гэсэн хариу мэдэгджээ [8].

Хүснэгт 15. Орон нутагт хэрэгжүүлж буй эрчим хүч хэмнэлтийн талаарх ажил арга хэмжээ, үр дүн. Орон нутгийн 2023 оны төлөвлөгөө [8]

№	Нэрс	Барилгын дулаан алдагдал бууруулах	Шугам сүлжээний дулаан алдагдал бууруулах, шинэчлэл	Улайсдаг чийдэнг хэмнэлттэй Лед гэрлээр шинэчлэх	Хэмнэл-тийн сургалт сурталчил-гаа зохион байгуулалт	Дулааны тоолуур-жуулалт	Бодлого хэрэгжүүлэ-хэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх	Хөрөн-гө оруу-лалт сая,төг
1	Архангай	0	0	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	0
2	Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0
3	Булган	0	0	0	0	0	0	0
4	Баянхонгор	0	0	0	0	0	0	0
5	Говь-Сүмбэр	0	0	0	0	0	0	0
6	Говь-Алтай	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	127
7	Дархан-Уул	0	0	0	0	0	0	0
8	Дорнод	0	0	0	0	0	Төлөвлөсөн	0
9	Дорноговь	0	0	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0	0	0
11	Нийслэл	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	Төлөвлөсөн	1,737.0
12	Орхон	0	0	0	0	0	Төлөвлөсөн	0
13	Увс	0	0	0	0	0	Төлөвлөсөн	0
14	Өмнөговь	0	0	0	0	0	0	0
15	Өвөрхангай	0	0	0	0	0	0	0
16	Хөвсгөл	0	0	0	0	0	0	0
17	Ховд	0	0	0	0	0	0	0
18	Хэнтий	0	0	0	0	0	0	0
19	Завхан	0	0	0	0	0	0	0
20	Сүхбаатар	0	0	0	0	0	Төлөвлөсөн	0
21	Сэлэнгэ	0	0	0	0	0	0	0
22	Төв	0	0	0	0	0	0	0
Нийт		**2**	**2**	**3**	**3**	**3**	**7**	**1,864.0**

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 7.3 дахь заалт буюу эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх тухайд хэрэгжилт мөн хангалтгүй байна. Тухайлбал, 2018 онд Архангай, Булган, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Дорнод, Увс, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв гэсэн 12 аймгаас, 2019 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон, Увс, Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Төв гэсэн 12 аймгаас эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг ирүүлсэн байна [13].

Харин 2022 оны байдлаар, ердөө 7 газраас тайлан ирүүлсэн. Үүнд: Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Нийслэл ирүүлжээ. Уг тайлангаар Архангай, Орхон, Нийслэл 2022 онд нийт 27,100

сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 924.6/146.98 кВт.цаг төгрөг цахилгаан эрчим хүч, 31,213.1/358.6 Гкал/төг дулааны эрчим хүч хэмнэж мөнгөн дүнгээр 414.1сая.төг хэмнэсэн гэсэн тооцоолол ирүүлсэн.

Хүснэгт 16. Орон нутгийн 2022 оны тайлан.

№	Нэрс	Барилга байгуулам-жийн дулаан алдагдал бууруулах	Шугам сүлжээний дулаан алдагдал бууруулалт, шинэчлэл	Улайсдаг чийдэнг хэмнэлттэй Лед гэрлээр шинэчлэх	Хэмнэл-тийн сургалт сурталчил-гаа зохион байгуулалт	Шаардлага-тай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүү-лэх	Хөрөнгө оруу-лалт сая.төг	Хэм-нэлт сая. төг	Хувь
1	Архангай	0	0	0	ААН, айл өрх	0	0	0	0
2	Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0	0
3	Булган	0	0	0	0	0	0	0	0
4	Баянхонгор	0	0	0	0	0	0	0	0
5	Говь-Сүмбэр	0	0	0	0	0	0	0	0
6	Говь-Алтай	0	0	0	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0	0	0	0
8	Дорнод	0	0	0	0	0	0	0	0
9	Дорноговь	0	0	0	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0	0	0	0
11	Нийслэл	41ш	Хэрэглэгчийн шугам хоолой	2802ш 250Вт гэрэлтүүлгийг 100Вт лед	0	1	26,580.0	414.08	80
12	Орхон	10ш	Дотор шугам хоолой	Гэрэлтүүлэг шинэчлэх	0	1	1,580.0	0	96.6
13	Увс	0	0	0	0	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0	0	0	0
15	Өвөрхангай	0	0	0	0	0	0	0	0
16	Хөвсгөл	0	0	0	0	0	0	0	0
17	Ховд	0	0	0	0	0	0	0	0
18	Хэнтий	0	0	0	0	0	0	0	0
19	Завхан	0	0	0	0	0	0	0	0
20	Сүхбаатар	0	0	0	0	0	0	0	0
21	Сэлэнгэ	0	0	0	0	0	0	0	0
22	Төв	0	0	0	0	0	0	0	0
Нийт		**51**	**2**	**2**	**1**	**2**	**27,160.0**	**414.1**	**0**

Эндээс дүгнэхэд Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах заалтууд практикт бүрэн хэрэгждэггүй байна. Эдгээр заалтын хэрэгжилт дутмаг байгаа шалтгааныг тодруулахаар аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтнүүд болон орон нутгийн зохицуулах зөвлөлийн гишүүдээс авсан судалгаагаар төсөв, санхүү хүрэлцдэггүй, удирдлагууд энэ чиглэлийн хууль тогтоомжийн талаар мэдээлэл дутмаг байдаг, хэрэглэгчийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй зэрэг шалтгааныг дурдсан байна [12]. Мөн Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс тодруулахад орон нутагт эрчим хүч хэмнэлтийн асуудлыг эрхэлсэн албан тушаалтны нөөц дутмаг, орон нутгийн удирдлагууд эрчим хүч хэмнэлтийн талаар мэдлэг мэдээлэл хангалтгүй, орон нутгийн төр захиргааны байгууллагууд эрчим хүч хэмнэлтийн талаарх ажил арга хэмжээ хийгдэхгүй байгаа нь ойр ойрхон удирдлагууд солигддогтой холбоотой гэсэн тайлбарыг өгсөн [8].

Дээрх мэдээлэл, судалгаанаас дүгнэхэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн талаар хуулийн 7.1-7.3 заалтууд хангалттай хэрэгжихгүй байна гэж дүгнэж байна.

3.3. ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

3.3.1. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх, үүрэгтэй холбоотой холбоотой зохицуулалт

Хүснэгт 17. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн шалгуур үзүүлэлт.

Үнэлэгдэх хэсэг	8.1.Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ. 8.2.Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна. 9.1.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; 9.1.3.үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар хийсэн ажлын жилийн тайлан, гүйцэтгэлийг гаргуулж авах; 9.1.4.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх; 9.1.5.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох; 9.1.6.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох; 9.1.7.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийн систем бүрдүүлэх, энэ талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.8.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах; 9.2.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь энэ хуулийн 9.1.7, 9.1.8-д заасан бүрэн эрхийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх нь практикт нийцэж байгаа юу?

8.1 дэх заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн бодлого зөвхөн эрчим хүчний салбараар хязгаарлагдахгүй дэд бүтцийн бүх салбарт хамаарах ёстой. Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг бүх салбарт хэрэгжүүлэхийн тулд эрчим хүч болон бусад салбарын бодлогын баримт бичигт тусгаж, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. Энэхүү заалт нь үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн хүрээнд барилга, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, уул уурхай, хүнд үйлдвэрлэл, үйчилгээ, мэдээлэл технологийн салбарт хэрэгжиж байна.

8.2 дахь заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж буюу ЭХЗХ-ний Эрчим хүч хэмнэлтийн газар нь дараах үндсэн үүрэгтэй ажилладаг.

- Эрчим хүч хэмнэлтийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Төрийн бодлого, Үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлж, бүртгэх, мэдээ, тайлан авах;
- Эрчим хүч хэмнэлтийн мэргэжилтнүүд /Аудитор, менежер/-ийг бэлтгэх, эрх олгох;
- Мэргэжлийн байгууллага /Аудитын байгууллага, эрчим хүчний үр ашгийн мэргэжлийн байгууллага/-ыг магадлан итгэмжлэх;

- Мэдээллийн системийг бий болгох, хуулийг сурталчлан таниулах;

Энэ заалт нь практикт хэрэгжиж байна.

9.1.1 дэх заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлдэг. Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй газар байдаг. Энэ заалт нь практикт хэрэгжиж байна.

9.1.3 дахь заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь Үүрэг хүлээсэн хэрэглэгчид, төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас тайлан, мэдээлэл хүлээн авч боловсруулах, нэгдсэн дүн шинжилгээ хийх, судалгаа тайлан гаргах, мэдээлэл солилцох, зөвлөмж чиглэл өгөх, Магадлан итгэмжлэл хүсэгчдийн хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, Эрчим хүчний онлайн сургалтын платформыг үүсгэх, олон нийт хэмнэлтийн чиглэлээр шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг цаг алдалгүй авах боломжийг нээсэн www.ecc.erc.gov.mn домэйн нэр бүхий цахим системийг нээсэн. Энэхүү цахим системд үүрэг хүлээсэн хэрэглэгчид болон орон нутагт эрчим хүч хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөө, тайланг авч ажилладаг байна [13].

9.1.4 дэх заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Засгийн газрын 2023 оны 67 дугаар тогтоолоор үүрэг хүлээсэн хэрэглэгчийн босго хэмжээг шинэчлэн батлуулсан. Улмаар ЭХЗХ-ны 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх тухай” 487 дугаар тогтоолоор үүрэг хүлээсэн хэрэглэгчийг шинэчлэн бүртгэсэн бөгөөд үүрэг хүлээсэн хэрэглэгчийн тоо 130-аар нэмэгдэж нийт 279 хэрэглэгч болж хуулийн үйлчлэх цар хүрээг тэлсэн. [23] Улмаар үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 2023 оны хэрэглээний мэдээлэлд үндэслэн тус хэрэглэгчдийн бүртгэлд Хорооны 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 416 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж одоогоор 226 үүрэг хүлээсэн хэрэглэгч “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-аар хүлээсэн эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна [24].

9.1.5 дах заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ыг баталсан байна.

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын дэмжлэгээр гүйцэтгэлийн гэрээний талаар судалгаа хийх, гэрээний загвар, зохицуулалтын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн хуульчтай хамтран ажилласан. Хуулийн гэрээт ажилтантай 2018 оны 07-р сарын 02-нд гэрээ байгуулан ажилласан бөгөөд хууль зүйн орчны судалгааны тайланг 2019 оны 07-р сарын 08-ны өдрийн ЭХЗХ-ны зохицуулагчдын зөвлөлийн хуралдаанаар танилцуулж дэмжигдсэн. Мөн Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрчим хүчний үр ашиг 3+” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Эрчим хүч хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын зах зээлийн механизмыг бүрдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох” ажлыг тусгуулан төслийг удирдах хорооны хурлаар хэлэлцэж баталсан байна [13].

Тус Эрчим хүч хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын зах зээлийн механизмыг бүрдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлын хүрээнд олон улсын богино хугацааны зөвлөх байгууллагаар шалгарсан Германы Эрчим хүчний агентлагтай 2018 оны 8-р сард гэрээ байгуулсан. Германы эрчим хүчний агентлагаас ажлын даалгаврын хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээн авсан. Тайланд хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг Олон Улсад гүйцэтгэлийн гэрээгээр зохицуулдаг бөгөөд хатуу журам гаргах нь хэрэгжилт сулрах, эрсдэлийг өндөрсгөх, хөрөнгө оруулалтыг сулруулах талтай гэж зөвлөсөн. Энэ ажлын хүрээнд АНУ, БНХАУ, ХБНГУ, ОХУ, Казахстан, Энэтхэг зэрэг улс орнуудын гүйцэтгэлийн гэрээний загваруудыг судлан өөрийн

орны хууль, эрх зүйн орчинд нийцсэн “Гүйцэтгэлийн гэрээ”-ний загварыг боловсруулж дуусгасан. Энэхүү гэрээний загварт мэргэжлийн хууль зүйн дүгнэлт өгөх ажлыг Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын санхүүжүүлэн ажилласан бөгөөд энэхүү Гэрээний загварыг эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага болон захиалагч гарын авлага, зөвлөмж байдлаар ашиглах нөхцөл бүрдсэн. Мөн эдгээрийг Эрчим хүчний зохицуулах хорооны цахим сайтад байршуулж олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан байна. Одоогийн байдлаар Эрчим хүчний зохицуулах хорооноос магадлан итгэмжлэгдсэн дараах хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагууд байна [13].

Хүснэгт 18. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагууд.

Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага	**Үйл ажиллагааны төрөл**
“Эм эм эс инженеринг” ХХК “Монгол базальт” ХК “Анд энерги” ХК	Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага;

Аудитын тухайд, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 оны 05-р сарын байдлаар 113 эрчим хүчний аудитор аудитын үйлчилгээ үзүүлж байгаагаас 39 аудитор бие даан, 74 аудитор 14 аудитын байгууллагад харъяалагдан ажиллаж байна. 2023 онд нийт 14 аудитын байгууллага 34 үүрэг хүлээсэн хэрэглэгч дээр аудит хийсэн байна [11].

9.1.7 дах заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, нийтэд сурталчлах, танин мэдүүлэх чиглэлээр:

- 15 төрлийн график видео, сурталчилгаа;
- 8 төрлийн бодит сурталчилгаа;
- 5 төрлийн радио сурталчилгаа;
- 10 төрлийн гарын авлага;
- 4 төрлийн зөвлөмж;
- 3 төрлийн ЕБС-ийн багш, хүүхдүүдэд зориулсан контент, 30 төрлийн брошур, гарын авлага, 10 төрлийн видео хичээл;
- 16 төрлийн өдөрлөг, аян уралдаан тэмцээн;

ЭХЗХ-ны албан ёсны Facebook хуудсаар эрчим хүчний системийн оргил ачааллын мэдээ, хэмнэлт, үр ашгийн зөвлөмж, мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэн ажилладаг байна.

http://ecc.erc.gov.mn хэмнэлт, үр ашгийн цахим мэдээллийн системийг 2018 онд шинээр бий болгон хөгжүүлсэн байна. Цахим системээр дамжуулан хэрэглэгч олон нийтэд эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх талаар холбогдох мэдээллийг тасралтгүй түгээх нөхцөл бүрдсэн. Цахим мэдээллийн системээр үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн мэдээллийн хуудас, төлөвлөгөө, тайлан, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг хүлээн авч, тайлан, төлөвлөгөөнүүдийг нэгтгэн ашиглаж байна [2]. Эндээс харахад энэхүү заалтын хэрэгжилт хангалттай гэж үзэж болохоор байна.

9.1.6, 9.1.8 дах заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүчний аудитор, хэмнэлтийн менежер бэлтгэх хүрээнд ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль, Барилга, архитектурын сургуультай хамтран ажилладаг ба 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт эрчим хүчний аудитор 113, эрчим хүч хэмнэлтийн менежер 503, нийт 616 мэргэжилтнийг сургаж бэлтгэн гэрчилгээ олгосон байгаа ба уг заалтын хэрэгжилт хангалттай гэж дүгнэж болохоор байна.

9.2 дах заалт практикт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүчийг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх талаар мэдээллийн систем бүрдүүлэх, энэ талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь 9.1.7-д

дурдсан ажлыг тогтмол хийж гүйцэтгэдэг. Монгол улсын эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар Эрчим хүчийг зөв зохистой хэрэглэх сурталчилгааг хийх замаар эрчим хүчний хэрэглээг бууруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд хэрэглэгчдэд эрчим хүчний зөв зохистой хэрэглээг сурталчлах, танин мэдүүлэх зорилготой “Тог-оо тохируулъя” аяныг Америкийн олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-тай хамтран хэрэгжүүлсэн байна.

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК, Барилгын хөгжлийн төв, ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль, Барилга архитектурын сургуультай “Сургалт зохион байгуулах, хамтран ажиллах” гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээрээс дүгнэхэд эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь эрчим хүчийг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх талаар нийтэд сурталчлах, эрчим хүчний аудитор, хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

3.3.2. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөртэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 19. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	9.1.2.Эрчим хүч хэмнэлтийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах;
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа юу?

<u>9.1.2 дах заалт практикт хэрэгжиж байгаа юу?</u>

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Эрчим хүчний яамнаас нийт 18 зорилт, 61 заалтын хүрээнд үнэлэхэд 97%-тай дүгнэгдсэн байна [13]. *Энэхүү заалт нь хөтөлбөрийн хүчинтэй хугацаанд практикт нийцсэн байна.* Цаашид үндэсний хөтөлбөрийг дахин боловсруулах шаардлагатай эсэхийг судалж, тухайн заалтыг шинэчлэн найруулах шаардлагатай.

3.3.3. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар тайлагналттай холбоотой зохицуулалт

Хүснэгт 20. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлагналтыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	9.1.10.Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах;
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа юу?

Эрчим хүч хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнадаггүй. Харин эрчим хүчний хэмнэлтийн талаар төрийн бодлогыг Засгийн газарт жил бүр тайлагнасан байна (*дэлгэрэнгүйг тайлангийн 3.2.2-с харна уу*).

3.3.4. Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалт

Хүснэгт 21. Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой маргаан шийдвэрлэхийг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	9.1.11.эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх.
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж байгаа юу?

Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон маргаан гарсан тохиолдолд шийдвэрлэх тусгайлсан журам байдаггүй. Харин Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний аудит хийх журам”, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-д маргаан, гомдол шийдвэрлэхтэй холбоотой дараах заалтууд тус тус туссан байна:

- 6.1. Аудитын байгууллага болон аудиторын хууль бус үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой үйлчлүүлэгчээс гаргасан гомдол, хүсэлтийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл шийдвэрлэнэ.
- 6.2. Энэ журмын 6.1-д заасан Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн гаргасан шийдвэрийг талууд эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.
- 7.3. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой маргааныг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл шийдвэрлэнэ.
- 7.4. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.

Одоогийн байдлаар дээрх журмуудын хүрээнд үүссэн гомдол, маргаан гараагүй тул практикт нийцэж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

3.4. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГСЛҮҮД ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

3.4.1. Засгийн газраас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмуудын үнэлгээ

Хүснэгт 22. Засгийн газраас баталсан журмуудыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	9.1.9.а.энэ хуулийн 13.3, 13.4-т заасан үйл ажиллагаатай холбогдсон эрчим хүчний аудит хийх журам; 9.1.9.б.эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой журам; 9.1.9.в.эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбоотой журам; 9.1.9.д.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам;
Шалгуур үзүүлэлт	Практикт нийцэж буй байдал
Харьцуулах хэлбэр	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал батлагдсанаас хойш;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмууд практикт нийцэж байгаа эсэх?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 5.1.3 дахь заалтад зааснаар 9.1.9-т заасан журмыг Засгийн газар батлах бүрэн эрхийн хүрээнд дээрх 4 журмыг анх Засгийн Газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор баталж, 2019 оны 181 дүгээр тогтоолоор 9.1.9 а, б, д журмуудыг шинэчлэн баталсан байна [3-7].

Эдгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дөрвөн журам нь Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд эрх үүргээ хэрэгжүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн ажлыг зохион байгуулахад баримтлах гарын авлага бүхий журмууд бөгөөд хуулийг хэрэгжүүлэгч оролцогч талуудтай харилцах харилцааг нарийвчилсан зохицуулсан. Журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш гарсан үзүүлэлт, үр дүнг Хүснэгт 23-24-т харуулав.

Аудит хийх журмын дагуу Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш аудитор болон аудитын байгууллагаас нийт 214 аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд журмын 3.1 дэх заалтад заасны дагуу 3 төрлийн аудитыг жил бүр гүйцэтгэсээр ирсэн байна [4]. Үнэлгээ 3.5.1-ийн Хүснэгт 28-аас дэлгэрэнгүй тоон мэдээллийг харна уу.

Мөн Үүрэг хүлээсэн хэрэглэгч (ҮХХ)-ийг тодорхойлох, тэдгээрийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журмын 3.1.8-д эхний аудит хийлгэснээс хойш 36 сараас хэтрэхгүй хугацаанд дараагийн шатны аудит хийлгэх гэж заасны дагуу 2020 оноос хоёр дахь шатны хэсэгчилсэн аудитууд хийгдэж эхэлсэн ба гурав дахь шатны аудитыг 2023 онд 3 удаа гүйцэтгэжээ [4].

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 503 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь эрчим хүчний аудиторууд болон аудитын байгууллагуудаас ирүүлсэн тэдгээрийн жилийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэсэн аудитын тайлан, зөвлөмжийн чанарт жил бүр үнэлгээ хийдэг [12].

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрчим хүчний аудитын байгууллага болон Эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ын дагуу өөрийн эрх үүргийн хүрээнд 14 аудитын байгууллагыг, 3 эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг бүртгэсэн. Эдгээр байгууллагууд нь хууль, журамд заасан эрх үүргийнхээ хүрээнд эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлдэг [5].

Тус журмын 2.3 дахь заалтад Эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад магадлан итгэмжлэл олгоход тавигдах шаардлага буюу шалгуур үзүүлэлтийг заасан. Энэ шалгуур үзүүлэлт болон Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 14.3-т эрчим хүчний мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдлийг хариуцна гэж заасан тул эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд харьцангуй цөөхөн бүртгэгдсэн байна. Тиймээс энэ байгууллагын хэрэгжүүлэх боломжтой эрх үүргийг сайтар судалж, бусад улс оронд эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын сайн туршлагыг судалж, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах шаардлагатай юм [5].

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “ҮХХ-ийг тодорхойлох, ҮХХ-ийн хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын хүрээнд тус журмын 2.1 болон 2.2 дахь заалтуудын дагуу нийт 226 ҮХХ-ийг ангиллын дагуу бүртгэсэн байна [17].

Мөн тус журмын 2.7 дахь заалтын дагуу Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь ҮХХ-ийн босго хэмжээг 3 жил тутамд тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж Засгийн газарт өргөн барьж шинэчлэн тогтоодог. Хууль батлагдсанаас хойш 2016, 2019 болон 2023 онуудад ҮХХ-ийн босго хэмжээг 3 удаа тогтоосон бөгөөд Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс ҮХХ-ийн бүртгэлийн талаар мэдээллийг албан ёсоор мэдэгддэг байна [7].

Хүснэгт 23. Бүртгэлтэй үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн мэдээлэл [17]

ҮХХ-ийн ангилал	**ҮХХ-ийн төрөл**	**2024 оны 9-р сарын 20-ны өдрийн байдлаар**
Барилга	Төрийн байгууллага	2
	Худалдаа оффис	18
	Үйлчилгээ, Эрүүл мэнд	5

Эрчим хүч хэрэглэгч	Уул уурхай	41
	Аж үйлдвэр- Хүнд үйлдвэр	20
	Аж үйлдвэр- Хүнсний үйлдвэр	42
	Аж үйлдвэр- Хөнгөн үйлдвэр	38
	Мэдээлэл холбоо	6
	Бусад	28
Эрчим хүчний салбар	Эрчим хүч үйлдвэрлэгч	9
	Эрчим хүч дамжуулагч	3
	Эрчим хүч түгээгч, хангагч -цахилгаан	10
	Эрчим хүч түгээгч, хангагч -дулаан	4
Нийт ҮХХ-ийн тоо		**226**

Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам”-ын дагуу Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс холбогдох сургалтуудыг зохион байгуулж, цахилгаан, дулаан болон барилгын эрчим хүчний чиглэлээр нийт 113 аудиторуудыг бэлдэж, 503 эрчим хүчний хэмнэлтийн менежерт эрх олгосон байна [2].

Хүснэгт 24. Бүртгэлтэй Аудитор болон ЭХХ-ийн менежерийн тоон үзүүлэлт [17]

Аудиторуудын төрөл	**2024 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар**
Цахилгаан эрчим хүчний аудиторууд	39
Дулааны эрчим хүчний аудиторууд	22
Барилгын эрчим хүчний аудиторууд	39
Нийт	**113**
Бүртгэлтэй ЭХХ-ийн менежер	**503**

Одоогоор Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс магадлан итгэмжлэл авч, хүчин төгөлдөр үйл ажиллагаа явуулж байгаа 14 аудитын байгууллага, 226 үүрэг хүлээсэн хэрэглэгчид ногдох аудиторууд болон эрчим хүчний хэмнэлтийн менежерүүдийн тоог харьцуулан үзэхэд энэ журмын хэрэгжилт хангалттай түвшинд хэрэгжиж буйг илэрхийлж байна.

3.4.2. Батлагдаагүй байгаа журмуудтай холбоотой зохицуулалтын талаар үнэлгээ

Хүснэгт 25. Батлагдаагүй журмуудыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	9.1.9.г.эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам; 9.1.9.е.эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам;
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо хэрэгжиж байгаа
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Дээрх 2 журмыг батлуулаагүй байгаа нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн зорилтод хүрэх түвшинд нөлөөлж байна уу?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд 9.1.9.е. дах заалт дахь Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам /цаашид “урамшууллын журам” гэх/-ыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс

боловсруулж, Засгийн Газар бүрэн эрхийнхээ хүрээнд батлахаар заасан. Гэтэл тус журмын төслийг Засгийн газарт хэд хэдэн удаа өргөн барьсан боловч, өдийг хүртэл эцэслэн батлагдаагүй байна.

Тухайлбал, Эрчим хүчний сайдын 2019 оны 72 дугаар тушаалаар тус журмыг эцэслэн боловсруулж 2019 оны гуравдугаар улиралд багтаан Эрчим хүчний сайдын зөвлөлд танилцуулах үүрэг бүхий Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл болон холбогдох оролцогч талуудыг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсгийн хүрээнд олон улсад хэрэгжиж буй урамшууллын механизмуудыг судалж, тэдгээрийн сайн туршлагыг Монгол улсад үр дүнтэй хэрэгжих боломжит хувилбаруудыг тодорхойлсны үндсэн дээр журмын төслийг өргөн барьсан [18].

Эрчим хүчний хэмнэлтэнд урамшуулал олгох ажлыг хэрэгжүүлэхэд гол тулгардаг асуудал нь санхүүжилтийн хэлбэр байдаг бөгөөд олон улсад нийтлэг ашиглаж буй арга нь эрчим хүчний салбартай холбоотой татвар, төлбөр, хураамжаас бүрдэх орлогоос тусгай санг үүсгэх эсвэл эрчим хүчний үйл ажиллагаатай холбоотой төрийн үйлчилгээг ашиглахад төлөх шимтгэлээр санг санхүүжүүлэх арга байдаг ажээ [15].

Дээр дурдсан ажлын хэсгийн боловсруулсан журмын төсөлд [20]:

- Татварын хөнгөлөлтийг эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох,
- Эрчим хүчний хэмнэлт гаргаж, үр ашгийг дээшлүүлсэн ҮХХ, иргэн, ААНБ-ыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд татварын буцаан олголт олгох,
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр шалгаруулдаг оны ТОП - 100 аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах шаардлагад Эрчим хүчийг хэмнэлтийг хэрэгжүүлсэн талаарх үзүүлэлтийг тусгахаар тус тус заасан байдаг [19].

Гэтэл эдгээр дэвшүүлсэн санаа, аргууд нь Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, холбогдох татварын хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж буй тул Засгийн Газрын зүгээс дахин авч үзэхийг санал болгон хугацаагүй хойшлуулсан байдаг.

Иймд урамшууллын журам батлагдаагүйгээс шалтгаалан Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хангалтгүй хэрэгжиж, Үүрэг хүлээсэн хэрэглэгч, иргэн, бусад аж ахуй нэгж байгууллагын эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх санал, санаачлага хангалтгүй байна.

Түүнчлэн, 9.1.9г заалтад заасан “Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам” цаашид /***шошгожуулалтын журам*** гэх/ одоог хүртэл батлагдаагүй байна. Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлөөс Монгол Улсын хэрэглэгчдийн хэрэглээний сэтгэл зүйн онцлогт тохирсон Эрчим хүчний хэрэглээний шошгын хэлбэр хэмжээ, загварт тавигдах ерөнхий шаардлага [21]-ыг боловсруулж, журмын төсөл [22]-ийг мөн адил боловсруулан Засгийн газарт өргөн барьсан. Засгийн Газрын холбогдох яамдаас, шошгожуулалтын журамтай холбоотой саналыг авахад дараах хүснэгтэд харуулсан байдлаар саналууд ирүүсэн байна [23]. Сангийн яам, Гадаад харилцааны яам, Гаалийн Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн газруудаас санал ирээгүй байна.

Хүснэгт 26. Шошгожуулалтын журамд холбогдох яамдаас ирүүлсэн санал.

№	Яамдын нэр	Албан тоотын огноо, дугаар	Ирүүлсэн санал
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	2019.10.15 01/7098	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцлаа. 1. 1.1–д Энэ журмын зорилгыг өөрчлөх 2. 2.2-т Заавал шошго авах бараа бүтээгдэхүүнийг зааж өгөх.

			3. 3.4-т заасан харьцуулсан, нотолсон гэсэн шошгын загварыг хамтад нь авах эсвэл салгаж авахыг тодорхойлж өгөх. 4. 5.4.2-т заасан хугацаанд заавал авах шошгыг аваагүй бол хариуцлагыг зааж өгөх. 5. Эрчим хүчний хэмнэлттэй, хүрээлэн буй орчинд ээлтэй бараа бүтээгдэхүүнийг нотолсон “Ногоон лого”-г бараа бүтээгдэхүүнд нааж байх саналтай байна. Төслийг дэмжиж байна.
2	Барилга, хот байгуулал-тын яам	2019.10.11 01/3851	Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад, зарчмын хувьд дэмжиж байна.
3	Батлан хамгаалах яам	2019.10.15 1а/3887	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад дэмжиж байна. Эрчим хүчний хэмнэлттэй бараа бүтээгдэхүүнийг импортолсон, үйлдвэрлэсэн, хувь хүн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гаалийн тариф, гаалийн татварын бодлогоор дэмжих агуулга бүхий заалтыг нэмэх саналтай байна.
4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2019.10.16 1а/9040	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох,шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй.
5	Зам, тээврийн хөгжлийн яам	2019.10.16 02/5521	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж байна. Засгийн газрын тогтоолын төслийн үндэслэх хэсэгт үндэслэсэн “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3” гэснийг Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-д “Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл заалтыг тодорхой заана” гэж заасантай нийцүүлэн “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9.г” гэж өөрчлөн хуулийн заалтыг тодорхой тусгуулах саналтай байна.
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	2019.10.15 01/2888	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцлаа. Тухайлан өгөх саналгүй.
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	2019.10.15 1-1/4546	Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийн талаар дараах саналтай байна. Журмын төсөлд нотлох болон харьцуулсан шошгын загвар, түүнчлэн бараа бүтээгдэхүүн, цахилгаан тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэрэглээний гэрчилгээний загварыг батлах субъект нь тодорхойгүй байгааг анхаарах.
8	Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам	2019.10.11 2/3199	“Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөлтэй танилцлаа.

			Журмын төсөлд энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2019.10.09 01/3874	“Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад дэмжиж байна.
10	Эрүүл мэндийн яам	2019.10.04 1б/4638	“Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөл, “Эрчим хүчний хэрэглээний заавал шошго авах бараа бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалтай танилцаж, зарчмын хувьд дэмжиж дараах саналыг хүргүүлж байна. Танилцуулгад хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар тодорхой тусгана уу.

Эдгээр ирүүлсэн саналуудыг шошгожуулалтын журмын төсөлд тусгаж, Засгийн Газарт өргөн барьсан боловч өдийг хүртэл тус журам тодорхойгүй шалтгаанаар батлагдаагүй байна.

Дээр дурьдсанчлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт *“3.3.3.18. Эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.”* гэж тусгасан. Энэ хүрээнд шошгожуулалт болон урамшууллын журмыг баталж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн Эрчим хүчний хэмнэлтийн талаар хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн бодлогын тогтвортой байдал болон хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхийн тулд журмуудад тусгагдсан зарчмын шинжтэй заалтуудыг хуульд тусгах саналтай байна. Тухайлбал, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9.1.9-д заасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмууд нь тус хуулийг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай (аудит хийх, аудитын байгууллага болон мэргэжлийн байгууллагуудад магадлан итгэмжлэл олгох, аудиторуудыг сургах, аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, тэдний аудиторын эрхийг сунгах, хүчингүй болгох гэх мэт) харилцааг зохицуулсан байна.

Тиймээс эдгээр журмаар зохицуулсан харилцаа болон хуулийн уялдаа холбоог сайтар судалж, аудит хийх зарчим, аудиторууд болон мэргэжлийн байгууллагад эрх олгож, бүртгэхэд тавих шалгуур үзүүлэлт гэх мэт зарчмын шинжтэй зохицуулалтыг хуулийн тусгайлсан заалтаар зааж өгснөөр хуулийн хэрэгжилт болон тус хуулиар зохицуулж буй зохицуулалт илүү үр дүнтэй байх боломжтой юм.

3.5. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн зорилтыг хангахад чиглэгдсэн эрчим хүчний аудитын үйл ажиллагаа, эрчим хүч хэмнэлтийн үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, эрчим хүч хэмнэлтийн менежер, үүрэг хүлээсэн хэрэглэгч, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбоотой заалтын хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох шаардлагатай гэж үзэж уг хүрээг тогтоосон болно.

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүрээтэй холбоотой нийт 3 журам байна:

- Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам [3] - 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 295 дугаар Засгийн газрын тогтоолоор баталгаажиж мөрдөгдөж эхэлсэн.
- Эрчим хүчний аудит хийх журам [4] - 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 181 дугаар Засгийн газрын тогтоолоор батлагдсан.

- Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам [5] - Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

3.5.1. Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитортай холбоотой зохицуулалт

Хүснэгт 27. Аудитын байгууллага, аудиторуудтай холбоотой зааltыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	13.3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргах; 13.4.2. Үүрэг хүлээсэн хэрэглэгчид эдийн засгийн үр ашигтай, техникийн үндэслэлтэй зөвлөмжийг гаргаж өгөх;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардал, гарсан үр өгөөжийн харьцааг тогтоох, нийгэмд үр нөлөөтэй үйлчилж байна уу?

Эрчим хүчний аудит хийхтэй холбоотой дараах норм стандарт, аргачлалууд мөрдөгдөж байна:

Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн С/46 дугаар тушаалаар Европын Холбооны дараах стандартуудыг Монгол улсад хэрэглэхээр үндэсний стандартаар баталсан. Үүнд:

- *MNS EN16247-1: 2019 Эрчим хүчний аудит. Ерөнхий шаардлага.* Уг стандартад эрчим хүчний бүх төрлийн аудитад тавигдах ерөнхий шаардлагыг тусгаж, Эрчим хүчний аудит хийхэд тавих шаардлага, аргачлал, дэс дараалал ба гарах үр дүнг тайланд хэрхэн тусгахыг тогтоосон байна.
- *MNS EN16247-2: 2019 Эрчим хүчний аудит. Барилга.* Барилгын эрчим хүчний аудитын тусгай шаардлагыг тогтоосон. Энэ стандарт нь хувийн орон сууцнаас бусад барилга болон хотхонд тавих эрчим хүчний аудитын шаардлага, арга аргачлал, дэс дараалал, үр дүнг тайланд хэрхэн тусгахыг тогтоосон.
- *MNS EN16247-3: 2019 Эрчим хүчний аудит. Үйлдвэрлэл.* Энэхүү стандарт нь үйлдвэрлэлийн эрчим хүчний аудитын шаардлагууд, аргачлал ба үр дүнг тодорхойлно.
- *MNS EN16247-4: 2019 Эрчим хүчний аудит. Тээвэр.* Энэхүү стандарт нь тээврийн салбарт хийх эрчим хүчний аудитын шаардлага, арга зам болон үр дүнг тодорхойлно.
- *MNS EN16247-5: 2017 Эрчим хүчний аудит. Эрчим хүчний аудиторын ур чадвар.* Эрчим хүчний аудиторын ур чадвар стандартыг эрчим хүчний аудиторуудыг мэргэшүүлэх системийг үндэсний хэмжээнд тогтоох; тохирох ур чадвар бүхий эрчим хүчний аудиторыг эрчим хүчний аудитын байгууллагаас сонгон шалгаруулах; мөн түүнчлэн эрчим хүчний аудитыг дээрх стандартуудын хүрээнд чанарын өндөр түвшинд гүйцэтгэхэд ашиглана. Энэхүү стандартад эрчим хүчний аудитор болон эрчим хүчний аудит гүйцэтгэх байгууллагад тавих бусад холбогдох ур чадварыг тогтоосон байна.
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 146 дугаар тушаалаар батлагдсан барилгын эрчим хүчний хэрэглээ, гүйцэтгэлийг тодорхойлох “БНбД 25-01-20 Барилгын дулаан хамгаалалт” норм ашиглагдаж байна.
- Мөн Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 503 дугаар тогтоолоор “Эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлал” [11] батлагдан хэрэгжиж байна.

Эндээс үзэхэд Монгол Улсад эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудиторын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэхээр байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолоор “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)” батлагдсан. Хөтөлбөрт 2022 оны зорилтот түвшинг чиглэл бүрээр тусгаж ажилласан байна. Жишээ нь:

- Эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага 2022 оны түвшинд 15 байхаар;
- Эрх бүхий эрчим хүчний аудитор 2022 онд 100, эрчим хүчний хэмнэлтийн менежер 200 байхаар тусгасан байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш буюу 2016 оноос хойш эрчим хүч хэмнэлтийн менежер 503, мэргэжлийн байгууллага 17 - үүний 14 нь аудитын байгууллага, 3 эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага дээр дурдсан журмын дагуу магадлан итгэмжлэл, эрчим хүчний 113 аудитор аудит хийх эрхээ авсан байгаа ба 226 үүрэг хүлээсэн хэрэглэгчээс 150 байгууллага давхардсан тоогоор 214 аудит хийлгэсэн байна [2]. Хүснэгт 28-т хийлгэсэн аудитын тоог оноор үзүүлэв.

Хүснэгт 28. Хийлгэсэн аудитын тоо, оноор

Он	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	**Нийт**
Эхний аудит	20	37	21	36	20	19	11	1	**165**
Хоёр дахь аудит				6	9	19	11	1	**46**
Гурав дахь аудит							3		**3**
Хийлгэсэн аудитын тоо	**20**	**37**	**21**	**42**	**29**	**38**	**25**	**2**	**214**
2 дахь аудит хийлгэх хугацаа болсон				9	7	15	9	13	**53**
3 дахь аудит хийлгэх хугацаа болсон							9	7	**16**
Аудит хийгдээгүй		15	1	11					**27**
Шинэ ҮХХ-ийн эхний аудит							2	12	**14**
Нийт 2024 онд аудит хийлгэх									**108**

Хүснэгт 28-аас үзэхэд үүрэг хүлээсэн хэрэглэгчид жилд дунджаар 30 аудитын ажил хийлгэж, хэрэгжүүлж ажиллаж байна. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 214 аудит хийгдсэн байгаагийн 165 нь анхан шатны аудит буюу үйлчлүүлэгчийн эрчим хүчний хэрэглээний бэлэн байгаа, хялбар авч болох өгөгдөлд суурилсан эрчим хүч хэмнэх нөөц боломж, шууд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлсон үйл ажиллагаа хийгдсэн байна. Харин 46 хэсэгчилсэн аудит буюу анхан шатны аудитын дүгнэлтэд үндэслэгдсэн технологийн болон бусад үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн сонгосон тодорхой хэсгийн эрчим хүчний хэрэглээний нарийвчилсан судалгаа, өртөг, зардлын шинжилгээг хийж, хөрөнгө оруулалт, үр ашгийг тооцох үйл ажиллагаа хийгдсэн байна. Харин дэлгэрэнгүй аудит 3 байгууллага хийлгэсэн байна. Энэ нь өртөг зардал үнэтэй, ажлын эзлэхүүн, цар хүрээ ихтэй байдаг учир хэрэв дэлгэрэнгүй аудит хийлгэсэн тохиолдолд аудитын гаргасан зөвлөмжөөс хамаарч дараагийн аудит хийлгэх хугацааг тодорхойлдог болгох шаардлагатай байна. Тодруулбал, үүрэг хүлээсэн хэрэглэгч нь эрчим хүчний аудитыг 18 сарын дотор, цаашид хэсэгчилсэн эсхүл, дэлгэрэнгүй аудит хийлгэх ба аудит хоорондын хугацаа 36 сараас хэтрэхгүй байна [6] гэж журамд заасан ба дэлгэрэнгүй аудит хийлгэсэн тохиолдолд дараагийн аудит хийлгэх шаардлагатай 3 жилийн хугацааг уртасгах талаар зохицуулалт хийх нь зүйтэй.

Аудит хийгдээгүй 27, хэсэгчилсэн аудит хийлгэх хугацаа болсон 53, гурав дахь аудит хийлгэх хугацаа болсон 16 үүрэг хүлээсэн хэрэглэгч байгаа нь аудит хийлгэхгүй байх хандлага ажиглагдаж байна.

2020 оны байдлаар нийт 43 үүрэг хүлээсэн хэрэглэгч аудит хийлгэснээс 9 нь барилга байгууламж өмчлөгч, 11 нь эрчим хүчний хэрэглэгч, 23 нь эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага байсан ба аудитын тайланд нийт 704 зөвлөмжилсөн арга хэмжээг тусгасан байна *(Хүснэгт 29)*.

Хүснэгт 29. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт


Үүрэг хүлээсэн хэрэглэгч	Гүйцэтгэсэн аудитын тоо	Зөвлөмжил-сөн арга хэмжээ	Хэрэгжүүл-сэн арга хэмжээ	Хэмнэсэн эрчим хүч, мян.кВт.ц	Бууруулсан зардал, сая.төг	Зарцуулсан ХО, сая.төг
Барилга байгууламж	9	104	20	5957,8	109	1 281,3
Эрчим хүч хэрэглэгч	11	267	61	6422,6	2 198,9	1 294,7
Эрчим хүчний салбар	23	333	265	7 965,1	8 882,5	2 4291,7
Нийт	**43**	**704**	**346**	**92 031,5**	**11 190,4**	**26 867,7**

Тэдгээрийн 346 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 26.9 тэрбум төгрөг зарцуулж 92 ГВт*ц цахилгаан эрчим хүчийг хэмнэж, нийт зардлаа 11.2 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Үнээс үзэхэд аудитын дүнд зөвлөж буй арга хэмжээнүүдийн өртөг өндөр, зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээ нөхөх хугацаа урт гэж үзэж болохоор байна.

2024 оны 8 сард үүрэг хүлээсэн хэрэглэгчид дунд ЭХЗХ-ноос явуулсан санал асуулгын [7] дүнгээс үзэхэд нийт үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 54% нь эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг бодит санхүүгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт гэж үздэг гэсэн байна. Харин 19% нь үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ гэж үздэггүй гэсэн байна.

Уг судалгааны дүнд: аудитын үйлчилгээний төлбөрийг өндөр; аудитын үйлчилгээг ач холбогдол багатай; хэрэглэгчийн эрчим хүчний үнэ тариф бага, зардалд нь нөлөөлдөггүй тул аудитын үйлчилгээг үл ойшоох хандлагатай байдаг гэсэн дүгнэлт гарсан байна.

Эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлалын [11] дагуу эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэл бүхий 14 байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн байна *(Зураг 1)*.



Зураг 1. Аудитын байгууллагуудын үйл ажиллагааны үнэлгээ

2023 онд 14 байгууллагаас 1 байгууллага эрчим хүчний аудитын үйл ажиллагаа явуулаагүй эсвэл тайлан, мэдээг тогтоосон хугацаанд ирүүлээгүй учраас хангалтгүй гэж үнэлүүлсэн байна. Харин 6 байгууллага хангалттай сайн, 6-сайн гэж үнэлэгдсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байгаа нь эрчим хүчний аудитын тайлангийн чанар тодорхой түвшинд сайжирч байгааг илтгэж байна [11]. Гэвч аудитын байгууллагыг дүгнэхдээ агуулыг биш мэдээ тайланг хугацаандаа ирүүлсэн эсэх, аудитын тайлангийн стандартын нийцлийн үнэлгээ, аудитын байгууллагад тавигдах шаардлага, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийн нийцлийн үнэлгээ болон аудитын үйл ажиллагаатай холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа зэргийг харгалзан үзэж байна.

Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудиторуудын дунд явуулсан судалгаагаар эрчим хүчний аудит хийх явцад үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн зүгээс шаардлагатай баримт материалуудыг гаргаж өгөх тал дээр идэвхгүй, хэмнэлтийн менежерээс бусад албан тушаалтнууд үүн дээр анхаарал хандуулдаггүй, аудиторуудаас хууль, гэрээнд заагаагүй чиг үүргийг хэрэгжүүлэхийг шаарддаг зэрэг хүндрэл бэрхшээлтэй асуудлууд тулгардаг талаар дурдсан байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2 дэх заалтад *“иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргах”* гэж заасан боловч энэ заалт нь зөвхөн үүрэг хүлээсэн хэрэглэгчийн дунд хэрэгжиж байна. Энэ нь аудитын үйлчилгээний төлбөр өндөр, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт их шаардагддаг мөн бусад иргэн, аж ахуйн нэгжийн хувьд аудит хийлгэж, эрчим хүчээ хэмнэх санал санаачлага гаргах шаардлагагүй байгаа нь эрчим хүчний үнэ хямд, эрчим хүч хэмнэх урамшууллын хөшүүрэг байхгүй, эрчим хүчний аудитын зардал, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт зэргийг нөхөх хугацаа урт байгаатай холбоотой байна.

Харин хэмнэлтийн хуулийн 13.4.1 дэх заалт *“үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээ, үр ашгийг тооцох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах”* -ын хувьд хэрэгжилт хангалттай буюу нийт 92 ГВт*ц эрчим хүч хэмнэж, 27 тэрбум төгрөг зарцуулж, одоогоор 11 тэрбум төгрөгөөр зардлаа бууруулсан байна.

Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудиторын үүргийг хуульчилсан боловч энэхүү үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд заагаагүй байна.

3.5.2. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагатай холбоотой зохицуулалт

Хүснэгт 30. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	3.1.7. “Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага” гэж үүрэг хүлээсэн хэрэглэгч болон хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг хэлнэ. 14.2. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 14.3. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагатай холбоотой заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3.1.7 болон 14.2 дугаар заалтууд агуулгын хувьд зөрчилдөж байна: 3.1.7-д “*эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага гэж үүрэг хүлээсэн хэрэглэгч болон хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрчим хүч хэмнэх, үр ашиг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг хэлнэ”* гэж заасан бол 14.2-т “*эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”* гэж заасан байна. Тодруулбал эдгээр заалтууд нь 2 талаараа зөрчилдөж байна: хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах эсвэл зөвхөн үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх мөн эрчим хүчний мэргэжлийн байгууллагын эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээ нь ажил эсвэл үйлчилгээ гэсэн тодорхойлолтын алинд хамаарах нь тодорхойгүй байна.

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 14.3 дугаар заалтаар эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна гэж хуульчилсан. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн байгууллагууд нь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйлчилгээг өөрөө хөрөнгө гаргахын хажуугаар хэмнэлт гарна гэж баталгаа гарган хийх ба үйлчилгээний төлбөр нь төслийн гүйцэтгэлтэй буюу эрчим хүч хэмнэсэн үнийн дүнтэй шууд холбоотой байна. Тооцоолж буй хэмнэлтийг гаргаагүй бол тус мэргэжлийн байгууллага нь ажлын хөлсөө авахгүй эрсдэлтэй байна.

Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагууд ихэвчлэн дараах үйлчилгээг үзүүлдэг: эрчим хүчний үр ашгийн төслүүдийг хөгжүүлэх, загвар хийх, эрчим хүчний үр ашиг өндөртэй

тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, ашиглах, эрчим хүч хэмнэлтийн төсөл хэмнэлт гаргаж байгаа эсэхийг хянах, хэмжих, шалгаж гэрчлэх.

Одоогийн байдлаар хөрөнгө оруулалтыг эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага өөрөө санхүүжүүлэх, эсвэл үйлчлүүлэгч санхүүжүүлэх, эсвэл гуравдагч этгээд буюу санхүүгийн байгууллага тусгайлсан сангаас үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага эсвэл үйлчлүүлэгчид шууд зээл өгөх байдлаар шийдэгдэж байсан туршлага байна [25]. Зээл нь төслийн хэрэгжилтээр бий болох эрчим хүчний зардлын хэмнэлтээс эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын өгсөн баталгаагаар эргэж төлөгддөг. Эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 2 үндсэн загварыг Эрчим хүчний зохицуулах хорооноос загварчилж өгсөн байдаг: үр ашгийг хуваах, хэмнэлтийн баталгаа гаргаж өгөх. Үр ашгийг хуваах загвар нь хэмнэсэн зардлыг үр ашгийн мэргэжлийн байгууллага болон үйлчлүүлэгч урд нь тохирсон хувиар, тодорхой хугацаанд хувааж авдаг ба энэ загварт гүйцэтгэл болон зээлийн аль аль нь эрсдэл дагуулдаг. Хэмнэлтийн баталгаа гаргах загвар дээр үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үйлчлүүлэгчид хэмнэлтийн тодорхой түвшин гарна гэж баталгаа өгдөг ба хүүний хувьд бага давуу талтай байдаг.

Хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд буюу 2024 оны түвшинд эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн 3 байгууллага магадлан итгэмжлэл авч, үйл ажиллагаа эрхлэх эрхтэй байгаа нь хөрөнгө оруулалтаа өөрөө хариуцдаг, хэмнэлтийн үр дүнгээс хамаарч үйлчилгээний төлбөрөө авах эрсдэлтэй байгаатай холбоотой байна.

Энэ төрлийн мэргэжлийн байгууллага үр ашгийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх эрх зүйн орчин сайжруулах, төрөөс тодорхой хэмжээний дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байна [7] гэж судалгаанд оролцсон үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 55% нь үзсэн байна. Жишээлбэл, эрчим хүчний үр ашгийн төслүүдийн эхний үе шатыг Засгийн газрын санхүүжилтээр шийдэх боломж, цаашдын хөгжих шатуудыг эрчим хүчний тарифын хэмнэлт болон эрчим хүчний хэрэглээний хэмнэлтээс бий болсон хөрөнгөөр санхүүжүүлэх, мэргэжлийн байгууллагад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох зэрэг бодлого, дэмжлэг шаардлагатай байна.

3.5.3. Эрчим хүчний хэмнэлтийн менежертэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 31. Эрчим хүчний хэмнэлтийн менежерийг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	15.2.2. Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах; 15.2.3. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хэмнэлтийн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих үүргийн хэрэгжилт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Үүрэг хүлээсэн хэрэглэгч эрчим хүч хэмнэлтийн менежер томилох үүрэгтэй гэж хуулийн 10.2.5 дугаар заалтад тусгасан байна.

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш буюу 2016 оноос хойш 503 эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэгдэн гэрчилгээ авсан ба 226 үүрэг хүлээсэн хэрэглэгч байна. Харин үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс авсан судалгаагаар [7] нийт хэрэглэгчдийн 32% нь эрчим хүч хэмнэлтийн менежерийн үндсэн ажлын байртай, 54% нь хавсран гүйцэтгэдэг, 7% нь эрчим хүч хэмнэлтийн менежергүй гэсэн байна. Ажил үүргийг хавсран гүйцэтгэж байгаа эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл үүсгэдэг талаар тодруулахад үндсэн ажлын хажуугаар хавсран гүйцэтгэж байгаа тул ажлын ачааллаас шалтгаалаад зэрэг хийхэд хүндрэлтэй, байгууллагын зүгээс эрчим хүч хэмнэлтийн менежерт дэмжлэг байхгүй, хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгодоггүй зэрэг шалтгааныг дурдсан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд эрчим хүч хэмнэлтийн менежерийн ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 15.2.2 болон 15.2.3-т заасан эрчим хүч

хэмнэлтийн менежерийн үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хэмнэлтийн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих үүргийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна [12]. Тиймээс эрчим хүч хэмнэлтийн менежерийн ажил, албан тушаалыг үүрэг хүлээсэн хэрэглэгчийн үндсэн ажил, албан тушаал байхаар зохицуулах эсвэл эрчим хүч хэмнэлтийн менежерийн ажил, үүргийг хавсран гүйцэтгүүлэхээр бол гүйцэтгэлийн үр дүнг харгалзан нэмэгдэл олгох, тодорхой дэмжлэг үзүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

3.6. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ХҮРЭЭН ДЭХ ҮНЭЛГЭЭ

3.6.1. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 32. ҮХХ-ийг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	10.1 Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах эрхтэй: 10.1.1 эрчим хүчний аудитын байгууллагыг сонгох; 10.1.2 эрчим хүчний аудитын зөвлөмж, дүгнэлтийн талаар үндэслэлтэй тайлбар өгөхийг шаардах; 10.1.3 энэ хуулийн 13.4.2-т заасан зөвлөмжийг сонгон хэрэгжүүлэх; 10.1.4 эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд урамшуулал эдлэх. 10.2 Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах үүрэгтэй: 10.2.1 эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх; 10.2.2 эрчим хүчний хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх; 10.2.3 өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх; 10.2.4 эрчим хүчний аудитын тайлан, эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх; 10.2.5 эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилох, чөлөөлөх, энэ тухай Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд 14 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх; 10.2.6 эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон гомдлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Дээр дурдсанчлан, одоогоор 226 үүрэг хүлээсэн хэрэглэгч “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-аар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энд хугацаанд Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нэг л тохиолдол гарсан. Тухайлбал, 2021 онд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль зөрчиж, Зөрчлийн тухай хуулийн 12.9.1 дүгээр заалт буюу үүрэг хүлээсэн хэрэглэгч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр 1 үүрэг хүлээсэн хэрэглэгч 3,000,000 төгрөгийн торгуулиар шийтгэгдэж байсан байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүчний үр ашгийн түвшин сайжирч байна. Тухайлбал, Үүрэг хүлээсэн хэрэглэгчид сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 263.7 сая кВт.ц цахилгааныг буюу 47.7 тэрбум төгрөг хэмнэж [2], 197.78 тонн хүлэмжийн хийн ялгарлыг саармагжуулсан байна.

Гэсэн хэдий ч, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхлээд 9 жил өнгөрөх хугацаанд үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс урамшууллын механизм, ногоон зээлийн хүүг бууруулах, цахилгаан хөдөлгүүрүүдийг гаалийн татвараас чөлөөлөх талаар санал, хүсэлтийг жил бүр үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн үнэлгээг танилцуулах уулзалтын явцад тавьдаг. Урамшуулал, ногоон зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизм байхгүйн улмаас хэрэглэгчдийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх сэдэл жилээс жилд буурч байна. 2024 оны сүүлээр үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс эрчим хүч хэмнэлтийн хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой санал асуулгыг авахад [7]: эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэхэд ямар арга хэмжээг чухалчилдаг вэ? гэсэн асуулгад 70.8 хувь нь эрчим хүчний ачааллыг сааруулж, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, 53.9 хувь нь бодит санхүүгийн үр өгөөжтэй хөрөнгө

оруулалт гэж давхардсан тоогоор хариулсан байна. Мөн эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй арга хэмжээг нэрлэнэ үү? гэсэн асуулгад 58 хувь нь эрчим хүчний хэрэглээний менежментийг сайжруулах, 45 хувь нь урамшуулал-хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, 41 хувь нь тохируулах хэрэгсэл, шинэ технологийг бодлогоор дэмжих гэж хариулжээ. Эрчим хүчний хэмнэлтэд гэрчилгээ олгох зах зээлийн хөшүүргийн (урамшууллын) механизм нэвтрүүлэх саналыг 92 хувь нь шаардлагатай гэж дүгнэсэн. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, хэмнэлт гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагад төрөөс ямар урамшуулал, дэмжлэг үзүүлэх асуулгад 60 хувь нь гаалийн татварын хөнгөлөлт, 56 хувь нь орлогын албан татвараас чөлөөлөх, эрчим хүчний хэмнэлтэд огноо цуглуулж, урамшуулж дэмжих [7] гэж хариулсан.

Эндээс дүгнэхэд Үүрэг хүлээсэн хэрэглэгчид хуулиар тогтоосон эрх, үүргээ хэрэгжүүлж байгаа ч хуулийн хэрэгжилтийг урт хугацаанд хангаж, Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг эрчим хүч хэмнэх санал санаачлагыг нэмэгдүүлэхэд урамшууллын тогтолцоо нэн шаардлагатай байна.

3.6.2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт

Хүснэгт 33. Иргэн, ААНБ-ыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	11.1 Иргэн, аж ахуй нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй: 11.1.1 эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас зөвлөгөө авах; 11.1.2 сайн дурын үндсэн дээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийлгэх.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Иргэн, ААНБ-ын бүрэн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 11.1.2 дэх заалтад *“сайн дурын үндсэн дээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийлгэх”* гэж заасан боловч үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төдийлөн сайн дурын үндсэн дээр аудит хийлгэхгүй байна. Энэ нь эрчим хүчний үнэ хямд, эрчим хүч хэмнэх урамшууллын хөшүүрэг байхгүй, эрчим хүчний аудитын зардал өндөр, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтийг нөхөх хугацаа урт байгаатай холбоотой байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хувьд 2024 онд Эрчим хүчний сайдын тушаалаар: “Хэрэгцээг удирдах арга хэмжээ”-г нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, “Оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах диспетчерийн удирдлага, шуурхай зохицуулалтыг хэрэгжүүлэх”, “Хэрэглэгч, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, амьдралын дадал, хэвшил, зан төлөвт нөлөөлөл үзүүлж оргил ачааллын хэрэглээг бууруулах” гэсэн үндсэн 3 чиглэлээр ажлын хэсэг байгуулагдсан байна.

Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, эрчим хүчний яамны 2 сайдын хамтарсан тушаалаар “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох” журам батлагдсан. Энэхүү журам хэрэгжиж эхэлснээр ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй болон пассив барилгын үнэлгээний системийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, үнэлэх суурь нөхцөл бүрдсэн. Барилгын зураг төслийн магадлалын шатанд эрчим хүчний гэрчилгээ олгоно. Зураг төслийн магадлалын шатанд барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагааг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон бусад ашиглагдаж байгаа барилгад эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагааг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл хариуцахаар тус тус тусгаж өгсөн. Энэхүү журмын дагуу банкууд хуучин барилгад эрчим хүчний хэмнэлттэй зураг төсөл боловсруулсан тохиолдолд, эсвэл шинээр баригдах барилгын зураг төслийг эрчим хүчний хэмнэлттэй гэж тусгагдсан тохиолдолд ногоон зээл олгох нөхцлийг бүрдүүлж байна.

3.6.3. Урамшуулал олгохтой холбоотой зохицуулалт

Хүснэгт 34. Иргэн, ААНБ-д олгох урамшууллыг үнэлэх шалгуур.

Үнэлэгдэх хэсэг	12.1. Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулна.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг гаргасан иргэн, ААНБ-д урамшуулал олгох тухай 12.1 дах заалт хэр хэрэгжиж байна вэ?

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 12.1-т Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулахаар заасан.

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгаан эрчим хүч, хийн түлшний үнийн урамшууллын хэлбэр, хувь хэмжээг тогтоох, урамшууллыг улсын төсвөөс санхүүжүүлэх; 6.1.8-д зааснаар агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журмыг батлах бүрэн эрхийг тус тус олгосон байна.

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын хавсралтаар Агаарын тухай хуулийн 6.1.6-т заасан Гэр хорооллын цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам батлагдан хүчин төгөлдөр үйлчилж байна [12]. Энэ журмын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 1-ний өдрийн хугацаанд Гэр хорооллын айл өрхүүдэд оройн 21:00 цагаас үүрийн 06:00 цагийн хугацаанд хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг хөнгөлөх зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Энэхүү хөнгөлөлт нь тухайн гэр хорооллын бүс дэх эрчим хүч хэрэглэгчид хэрэглээний зан төлвөө өөрчлөх байдлаар эрчим хүчний хэмнэлт гаргах хөшүүрэг болж байгаа ч нийт хэрэглэгчид тэр дундаа Үүрэг хүлээсэн хэрэглэгчидэд чиглэсэн эрчим хүч хэмнэх, үр ашигийг нэмэгдүүлэхтэй холбоотой тэгш хүртээмжтэй урамшуулал олгох тогтолцоо биш юм.

Засгийн Газрын 2011 оны 309 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр бүлгийн 1.2.3-д заасан Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эрчим хүчний хэмнэлт буюу нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилгын нэгж талбайд ногдох эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлээр дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийг 2 дугаар бүлэгт, урамшууллын хэлбэрийг 3 дугаар бүлэгт, урамшуулах үйл ажиллагааг 4 дүгээр бүлэгт заасан байна. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан урамшууллын хэлбэр нь “***Ногоон Бүтээгдэхүүн**”, “**Ногоон Үйлчилгээ***”-ний гэрчилгээ олгож, энэ бүтээгдэхүүний дүрслэл бүхий шошгыг 2 жилийн хугацаанд хэрэглэх эрхийг олгох талаар заасан байна. Энэ гэрчилгээ олгох шийдвэрийг 4 дүгээр бүлгийн 4.5-т зааснаар Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүн гаргаж, 4.6-р заалтаар Цэвэр Агаарын Сангийн тухайн жилийн урамшуулал олгох зардалд энэхүү журмын урамшуулал олгохтой холбогдсон хөрөнгийг тусгаж, Цэвэр агаарын сангийн удирдах зөвлөлөөр батлуулна” гэж заасан байна. Энэ журам нь 2011 оноос хойш хүчин төгөлдөр үйлчилж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журам”-ын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мөнгөн бус дэмжлэг буюу “***Ногоон байгууллага***”-ын гэрчилгээ олгох, Бараа бүтээгдэхүүнд Эко тэмдгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас шалгуур үзүүлэлтийг тогтоон тусгай комисс ажиллан дээрх гэрчилгээ, тэмдгийг олгох эсэхийг шийдэж

байна. Энэхүү Ногоон гэрчилгээ болон Эко тэмдгийг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус журмын 8 дугаар зүйлд заасан 8 заалтын хүрээнд урамшуулал, дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулж мөнгөн бус дэмжлэгийг үзүүлж байна [12].

Гэсэн хэдий ч, Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаагаар эрчим хүчний хэмнэлт, үр ашиг гаргасан үүрэг хүлээсэн хэрэглэгчидэд олгох урамшууллын тогтолцоо хангалтгүй бөгөөд нэвтрүүлэх шаардлагатай буйг илэрхийлж байна [7]. Дээр дурьдсанчлан, 9.1.9.е.-д заасан урамшууллын журам эцэслэн батлагдаагүй байгаа нь 12.1 дэх заалт хангалттай хэрэгжихгүй байх нөхцөл бүрдэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Дүгнэлт

1. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр нийт эрчим хүч хэрэглэгчдэд эрчим хүчийг хэмнэх талаар ерөнхий ойлголтыг өргөн цар хүрээтэй ойлгуулахад өндөр хувь нэмэр оруулсан. Жишээ нь: эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлөөс Эрчим хүчийг хэмнэх талаар цахим хуудас ажиллуулах, Ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад эрчим хүч болон түүний хэмнэлтийн талаар хичээл орох, эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийг таниулах сургагч багш бэлдэх, тараах материал, шторк олон нийтэд хүргэх зэрэг үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлсэн байна.
2. Эрчим хүчний аудитын дүгнэлтээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлснээр нийт 92 ГВт*ц эрчим хүчний хэмнэлт гаргаж, 27 тэрбум төгрөг зарцуулж, одоогоор 11 тэрбум төгрөгөөр зардлаа бууруулсан байна. Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь эрчим хүчний аудитын зөвлөмж, болон эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр бусад төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр сүүлийн 5 жилд нийт 263.7 сая кВт.ц цахилгааныг буюу 47.7 тэрбум төгрөг хэмнэх боломжийг бүрдүүлсэн болон 197.78 тонн хүлэмжийн хийн ялгарлыг саармагжуулсан байна.
3. Гэсэн хэдий ч, Эрчим хүчний хэмнэлтийн талаар төрийн бодлого улсын хэмжээнд хэрэгжилт хангалтгүй буюу салбар хоорондын зохицуулалт, төрийн бодлогын уялдаа хангалтгүй байна.
4. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр боловсруулж, засгийн газар батлах тухай хуульчилсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор засгийн газрын үндэсний хөтөлбөр батлах бүрэн эрхийг хүчингүй болгосон ба Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүч хэмнэх чиглэлд баримтлах бодлогыг тодийлөн нарийн тусгагдаагүй байна. Тиймээс цаашид Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж хүрсэн үр дүнг ахиулахад хэмнэлтийн талаарх төрийн бодлогын тогтвортой орчныг бүрдүүлэх нь чухал байна.
5. Орон нутагт Эрчим хүч хэмнэлтийн талаар хуулийн болон төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.
6. Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага болон бусад оролцогч талуудын эрх, үүрэг тодорхой тусгагдаагүйн улмаас эрчим хүч хэмнэхтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирч байгаа тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, сайжруулах хэрэгцээ, шаардлага байна.
7. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох зохицуулалтыг хуульд тусгасан боловч холбогдох журмууд нь батлагдаагүйн улмаас эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг дэмжсэн урамшууллын тогтолцоо бүрдээгүй байна.
8. Урамшууллын журам батлагдаагүйгээс шалтгаалан Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хангалтгүй хэрэгжиж, Үүрэг хүлээсэн хэрэглэгч, иргэн, бусад аж ахуй нэгж байгууллагын эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх санал, санаачлага хангалтгүй байна.
9. Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд ангилал, зэрэглэл тогтоох шошгожуулах, хяналт тавих журам батлагдаагүйн улмаас эрчим хүчний үр ашигтай, дэвшилтэт машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааг нэвтрүүлэн, ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгчийг хамгаалах, зөв сонголт хийхэд туслах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой тогтолцоо бүрдээгүй байна.
10. Тиймээс цаашид эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.
11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргахаар хуульчилсан боловч зөвхөн үүрэг хүлээсэн хэрэглэгчид л хуулиар хүлээсэн үүргийн дагуу аудит хийлгэж байна. Хуулийн аудитын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалтанд үнэлгээ хийхдээ зардал-үр өгөөжийн харьцааг шинжилж үзэхэд эрчим хүчний аудитын зардал өндөр бөгөөд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа урт байна. Мөн Үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд аудит хийлгэж, эрчим хүчээ хэмнэх санал санаачлага гаргах шаардлагагүй байгаа нь эрчим хүчний үнэ

хямд, эрчим хүч хэмнэх урамшууллын хөшүүрэг байхгүй, эрчим хүчний аудитын зардал, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа урт байгаатай холбоотой байна.

12. Хуулийн 14.3 дах заалт буюу *“Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна.”* заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалтаа өөрөө гаргаж, эрсдэлээ өөрөө хариуцаж байгаатай холбоотой. Иймд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх эрх зүйн орчин сайжруулах, төрөөс тодорхой хэмжээний дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байна.
13. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 15.2.2 дэх заалт буюу Эрчим хүчний хэмнэлтийн менежер нь *“Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах;”* заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Энэ заалтын хэрэгжилтийг сайжруулахын тулд эрчим хүч хэмнэлтийн менежерийн ажил, албан тушаалыг үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн хувьд үндсэн ажил, албан тушаал байхаар зохицуулах эсвэл эрчим хүч хэмнэлтийн менежерийн ажил, үүргийг хавсран гүйцэтгүүлэхээр бол гүйцэтгэлийн үр дүнг харгалзан урамшуулах талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.
14. Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томъёоны нийцтэй байдлыг үнэлэхэд зарим нэр томъёо нь хоёрдмол утгатай, Эрчим хүчний тухай хуульд томъёолсон ойлголтуудтай зөрчилдөж байна. Үүнтэй холбоотой хууль хэрэгжүүлэх шатанд хуулийн зорилт, хамрах хүрээг тодорхойлоход ойлгомжгүй байдал үүсэхээр байна. Тиймээс хуулийн нэр томъёо төдийгүй хуулийн хамрах хүрээ, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг хуулийн үзэл баримтлал болон практикт хэрэгжиж буй байдалд нийцүүлэн нарийн тодорхой тусган шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж байна. Цаашлаад, Эрчим хүчний хэмнэлтийн талаар хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн бодлогын тогтвортой байдал болон хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхийн тулд журмуудад тусгагдсан зарчмын шинжтэй заалтуудыг хуульд тусгах нь зүйтэй юм.

4.2. Зөвлөмж

1. Одоо хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн зорилго, зорилтыг нарийн дэлгэрэнгүй тодорхойлох.
2. Эрчим хүч хэмнэх Үндэсний хөтөлбөрийг батлах шаардлагатай эсэхийг тодорхойлж, Монгол Улсын Хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон бусад хууль тогтоомжтой уялдуулан батлан гаргах.
3. Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд салбарын болоод салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс 6.1.3 дахь заалт *“6.1.3 эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх”* -ыг зөвхөн эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бус эрчим хүчний хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж буй бүх төрийн захиргааны төв байгууллагад хамаарахаар шинэчлэх.
4. Эрчим хүчийг хэмнэснээрээ авч болох урамшууллын талаар хуульд тусгах эсвэл урамшууллыг журмыг баталж, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.
5. Эрчим хүчний хэмнэлтийг зөвхөн Үүрэг хүлээсэн хэрэглэгч биелүүлэх, хэрэгжүүлэх бус үүрэг хүлээсэн гэх тодотголгүй бусад иргэн болон ААНБ-ууд өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх.
6. Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын магадлан итгэмлэхтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд, магадлан итгэмжлэлийг цуцлахтай холбоотой заалтуудыг хуульд тусгах.
7. Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн босго хэмжээг тогтоон батлах тухай бүрэн эрхийг Засгийн газрын бүрэн эрхэд оруулах.
8. Эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын эрх үүргийг нарийвчлан тодорхойлж, ямар үйл ажиллагаа хэрхэн явуулах талаар дэлгэрэнгүй тусгах.
9. Эрчим хүчний аудиторуудад эрх олгох шалгуур үзүүлэлтүүд, тэдний аудиторуудын эрхийг сунгах шалгуур, эрхийг цуцлах хүчингүй болгох талаар хуульд тодорхой тусгах.

10. Эрчим хүчний хэмнэлтийн аудитын байгууллага эсвэл эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болон Үүрэг хүлээсэн хэрэглэгч эсвэл эрчим хүчний аудитын үйлчилгээ авч буй оролцогч талуудын хооронд үүссэн болоод үүсч болзошгүй маргааныг хэрхэн зохицуулах талаар зохицуулалтын үйл ажиллагааг нарийн дэлгэрэнгүй тусгах.
11. 3.1.7-д эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага гэж үүрэг хүлээсэн хэрэглэгч болон хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрчим хүч хэмнэх, үр ашиг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг хэлнэ гэж заасан бол 14.2-т эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ гэж заасан байна. Эдгээр заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгааг залруулах.
12. Хуулийн хэрэгжилт нь хэрэглэгчдэд нээлттэй, ил тод байж, тэднийг мэдээллээр хангах шаардлагатай тул эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь хууль хэрэгжилтийн талаар хэрэглэгчдэд тайлагнах талаар заалт хуульд тусгах. Энэ нь хэрэглэгчдийн оролцоог нэмэгдүүлж, хуулийн үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой. Мөн хуулийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэрэглэгчдэд тайлагнах нь хууль хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, үнэн зөв мэдээлэл, ил тод байдлыг хангах ач холбогдолтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт. 2016 он.*
2. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан. *Эрчим Хүчний Зохицуулах Хороо. Инновац, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн конференцэд зориулсан танилцуулга. 2024 он.*
3. Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам. *Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолын хавсралт. 2016 он.*
4. Эрчим хүчний аудит хийх журам. *Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. 2019 он.*
5. Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам. *Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт. 2019 он.*
6. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам. *Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. 2019 он.*
7. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохтой холбоотой яамдаас, аудиторуудаас, аймаг, нийслэлийн засаг даргаас болон үүрэг хүлээсэн хэрэглэгчээс авах санал асуулга. *Эрчим хүчний зохицуулах хороо. 2024 он.*
8. Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт. *Эрчим хүчний зохицуулах хорооны товч танилцуулга. 2023 он.*
9. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022.4.21 өдрийн а/1576 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт. *2022 он.*
10. Эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлал. *ЭХЗХ-ны 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 503 дугаар тогтоолын хавсралт. 2022 он.*
11. Эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлсэн тайлан. *ЭХЗХ, Эрчим хүч хэмнэлтийн газар. 2024 он*
12. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааны тайлан. *Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм. 2020 он.*
13. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт. *Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022.4.21 өдрийн а/1576 тоот албан бичгийн хавсралт. 2022 он.*
14. Эрчим хүчний хэмнэлт цахим хуудас - https://ecc.erc.gov.mn/mn/
15. Эрчим хүчний сайдын 2019 оны “Ажын хэсэг байгуулах” тухай 72 дугаар тушаал.
16. Дэмжлэг үзүүлэх, урамшуулах олгох журмын нэгдсэн ойлголт, бүтэц танилцуулга. *Эрчим Хүчний Зохицуулах Хороо. 2019 он.*
17. Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмын төсөл. *Эрчим хүчний зохицуулах хороо. 2019 он.*
18. “Эрчим хүчний хэрэглээний шошгын хэлбэр хэмжээ, загварт тавигдах ерөнхий шаардлага” танилцуулга. *Эрчим хүчний зохицуулах хороо. 2020 он.*
19. Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмын төсөл. *Эрчим хүчний зохицуулах хороо. 2020 он.*
20. “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төсөлд яамдаас ирүүлсэн саналын товчоо. *Эрчим хүчний зохицуулах хороо. 2019 он.*
21. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал. *Монгол Улсын Засгийн Газар. 2015 он.*
22. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр 2018-2022. *Монгол улсын Засгийн газрын 274 дүгээр тогтоол. 2017 он.*

23. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх тухай. *Эрчим хүчний зохицуулах хорооны 487 дугаар тогтоол. 2023 он*
24. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх тухай. *Эрчим хүчний зохицуулах хорооны 416 дугаар тогтоол. 2024 он.*
25. Эрчим хүчний хэмнэлтэд анхын ЭСКО төсөл хэрэгжүүлэв. Цахим нийтлэл *https://www.monhorus.mn/esco/*.
26. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох журам. *Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 309 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт. 2011 он.*
27. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам. *Засгийн Газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. 2017 он*
28. Агаарын тухай хууль. *2012 он*
29. Шинэ сэргэлтийн бодлого. *УИХ-ын 2021 оны 106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.*
30. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл. *УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.*
31. Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр. *УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоол.*
32. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он
33. Засгийн газрын бүтцийн тухай хууль, 2024 он